## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

| Заалтын дугаар | Заалтын утга | Хэрэгжүүлэх төлөвлөгөө |
|---|---|---|
| НЭГ. ХҮН АМЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛ | | |
| Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын үйлчилгээгээр дамжуулан аі | | |
| 1.1 | Хүн амын амьжиргааны түвшингийн судалгааг шинэчлэн гаргаж ядуурлын шалтгаанд дүгнэлт хийж, уг үндсийг бууруулах,арилгахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, ядуурaлд өртсөн 450-иас доошгүй өрхийг ядуурлаас гарахад бодит дэмжлэг үзүүлнэ. | 1.1.1 Ядуу нэн ядуу өрхийн түвшинг тогтоох үзүүлэлт, журмыг шинэчлэн боловсруулж түүнийгээ үндэслэн нарийвчилсан судалгааг 2 жил тутамд аймгийн хэмжээгээр гаргана. |
| | | 1.1.2 Гаргасан судалгаагаа үндэслэн сумдын хүн амын тооноос хамааруулж тодорхой тооны амьдралын түвшин хамгийн бага өрхөөс сонголт хийн 450-иас доошгүй өрхийг ядуурлаас гаргахад бодит дэмжлэг үзүүлнэ. |
| 1.2 | Ажилгүйдэл ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд ажил идэвхтэй эрж буй иргэдийг ажлын байранд зуучилж,800-гаас доошгүй иргэнийг мэргэжлийн сургалтанд хамруулж,давхардсан тоогоор 3000 иргэнийг нийтийг хамарсан ажилд татан оролцуулж түр ажлын байраар хангана. | 1.2.1. Ажилгүй буюу ажил идэвхтэй хайгч мэргэжилгүй иргэдийг мэргэжлийн сургалтанд хамруулна |
| | | 1.2.2. аймаг дахь хорих ангид ял эдэлж буй иргэдэд барилгын чиглэлээр мэргэжил олгох сургалт явуулж, суллагдсаны дараа мэргэжлээрээ ажиллах нөхцөл бүрдүүлнэ. |
| | | 1.2.3. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг байнгын болон түр ажлын байраар хангана |

| | | |
|---|---|---|
| 1.3 | Нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай гэр оронгүй өрх, иргэдийг тодорхой журмын дагуу "Гэр" хөтөлбөрт хамруулна. | 1.3.1. Орон гэргүй иргэдийн судалгаанд түшиглэн гэр олгоно. |
| 1.4 | Өндөрхаан хотын нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж чадаагүй эмзэг бүлгийн өрхүүдийн түлээ,нүүрсний үнэнд 50.0 мянган төгрөгийн хөнгөлөлтийг жил бүр олгоно. | 1.4.1 Хэрлэн сумын нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаагүй эмзэг бүлгийн өрхүүдийн судалгааг гаргана |
| | | 1.4.2 Судалгаагаар нийгмийн халамжид хамрагдаагүй эмзэг бүлгийн өрх бүрт түлээ нүүрсний хөнгөлөлт 50.0 мянган төгрөг олгох буюу хөнгөлөлттэй үнээр түлээ олгоно. |
| 1.5 | Өндөрхаан хотын эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд бүхий өрхийн ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй хүүхдэд сурагчийн дүрэмт хувцсыг жил бүр олгоно. | 1.5.1 Хэрлэн сумын нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаагүй эмзэг бүлгийн өрхүүдийн хүүхдийн судалгааг 2 жил тутамд шинэчлэн гаргана. |
| | | 1.5.2 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаагүй эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд бүхий өрхийн ерөнхий боловсролын сургуулийн хүүхдэд 30.0 мянган төгрөгөөр тооцож сурагчийн дүрэмт хувцас олгоно. |

| | | |
|---|---|---|
| 1.6 | Хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ болон төвлөрлийг сааруулах шаардлагуудыг бодитой тооцож, аймгийн төв болон хот, сум, суурин газруудад нийтдээ 200 хүртэл айлын тохилог орон сууцны барилга барих ба амины орон сууц барьж буй иргэдийг дэмжиж ажиллана. | 1.6.1 Аймгийн төв болон хот, сум, суурин газруудад 200 хүртэл айлын тохилог орон сууцны барилгыг барина |
| | | 1.6.2 Аймгийн төвд амины орон сууц барих иргэдэд хөнгөлөлттэй зээл олгох ажлыг банкны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. |
| 1.7 | Хүүхэд залуучуудад зориулсан соёл амралтын хүрээлэнг байгуулахын зэрэгцээ хүүхдийн тоглоомын талбай 3-ыг шинээр байгуулна | 1.7.1.Хэрлэн,Батноров,Жаргалтхаан сум,Бор-Өндөр,Бэрх хотод хүүхэд залуучуудад зориулсан соёл амралтын хүрээлэнг байгуулна. |
| | | 1.7..2 Хэрлэн суманд хүүхдийн тоглоомын талбай 3-ыг шинээр байгуулна |

| | | |
|---|---|---|
| 1.8 | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төсөвт байгууллага аж ахуйн нэгж байгууллагуудад "Ахмадын сан" байгуулах, ахмадуудын чөлөөт цагийн танхимыг бий болгон тохижуулна. | 1.8.1 Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төсөвт байгууллага аж ахуйн нэгж байгууллагуудад "Ахмадын сан" байгуулж уг сангийн үйл ажиллагааг ахмадуудад төрөл бүрийн дэмжлэг үзүүлэхэд зарцуулна. |
| | | 1.8.2 Аймгийн төвд ахмадуудын чөлөөт цагийн танхим бий болгон тохижуулна. |
| | ДУНДАЖ ХУВЬ | |
| Хоёр. Боловсрол, соёл, ур | | |
| Боловсролын салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлэн сургалтын чанар хүртээмжийг дээшлүүлэхийн тулд багш нарын мэргэжлийн ёс з | | |
| 2.1 | Аймгийн боловсролын салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулан аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлнэ. | 2.1.1. Аймгийн боловсролыг хөгжүүлэх дэд төлөвлөгөө боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулна. |
| | | 2.2.1. Аймгийн хэмжээнд сурлагын амжилт, чанарын дундаж үзүүлэлтийг гарган мөрдөж ажиллана. |

| | | |
|---|---|---|
| 2.2 | Боловсролын шинэчлэлийг гүнзгийрүүлж, сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын сургалтын чанарыг сайжруулна. | 2.2.2. Сургууль, цэцэрлэг, багшийн үйл ажиллагааг арга зүйн удирдлагаар хангаж, хяналт үнэлгээ хийх ажлыг жил бүр төлөвлөн зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллана. |
| 2.3 | Боловсрол, соёлын газрын дэргэд "Багшийн хөгжил" сургалтын төв байгуулж, багш нарын мэргэшлийг дээшлүүлж, заах арга, ур чадварыг сайжруулна. | 2.3.1. "Багшийн хөгжил"-ийн төв байгуулна. |
| | | 2.3.2.Багшийн хөгжлийн төвд жил бүр 300-аас доошгүй багшийг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж, чадавхижуулна. |
| | | 2.3.3.Электрон сургалтын арга зүйг нэвтрүүлэх ажлыг өргөжүүлэх зорилгоор 200 багшийг мэдээллийн технологийн сургалтанд үе шаттай хамруулна. |
| | | 2.3.4 Жилд 8-аас доошгүй  цэцэрлэгийн багшийг мэргэжил олгох сургалтанд хамруулж, мэргэжилтэй багшийн тоог 70%-д хүргэнэ. |

| | | |
|---|---|---|
| 2.4 | Сургууль, цэцэрлэгийн сургалтын орчныг сайжруулах зорилгоор төсвийн болон олон улсын төсөл хөтөлбөрүүдийн эх үүсвэрийг ашиглан сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, тоглоом наадгайн хангалтыг нэмэгдүүлнэ. | 2.4.1. ЕБС-ийн компьютерийн хангалтыг одоогийн түвшнээс 50%-иас доошгүй хувиар нэмэгдүүлнэ. |
| | | 2.4.2. Жилд 3-аас доошгүй ЕБС-д компьютерийн лаборатор байгуулна. |
| | | 2.4.3. Хүүхэд бүрт компьютер хөтөлбөр, сургууль бүрт интернет номын сан байгуулах ажлыг эхлүүлнэ. |
| | | 2.4.4. СӨБ-ын тоглоом наадгайн хангалтыг нэмэгдүүлэх нэгдсэн бодлого боловсруулан шинэчилж, одоогийн байгаа түвшнээс 50%-иар нэмэгдүүлнэ. |
| 2.5 | "Үдийн хоол" хөтөлбөрийг цаг тухайд нь чанартай хэрэгжүүлж ажиллана. | 2.5.1. ЕБСургуулиудын гал тогооны цахилгаан тоног төхөөрөмжийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэн эрүүл ахуйн стандартад нийцүүлж, Үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилтэнд аймгийн МХГ-тай хамтран тогтмол хяналт тавьж ажиллана. |

| | | |
|---|---|---|
| 2.6 | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн барилгыг шинээр барьж, техник технологи, сургалтын төрөл агуулгыг өргөжүүлэн мэргэжилтэй ажилчин бэлтгэх, төгсөгчдийг ажлын байраар хангахад анхаарна. | 2.6.1 МСҮТ-ийн хичээлийн барилгыг шинээр барина. |
| | | 2.6.2."Фермерийн аж ахуй эрхлэлт" сургалтын бааз бий болгоход мэргэжлийн туслалцаа үзүүлнэ. |
| | | 2.6.3. ХХҮХ, МСҮТ-ийн ажлын уялдааг сайжруулж, МСҮТ төгсөгчдийг ажлын байраар хангахад анхаарч ажиллана. |
| 2.7 | Их дээд сургууль, коллежийн салбар сургуулийг Өндөрхаан хотод байгуулна. | 2.7.1. Өндөрхаан хотод МУИС-ийн салбарыг шинээр байгуулна. |
| | | 2.7.2. Соёл, урлагийн коллежийг шинээр байгуулна. |
| | | 2.7.3. Цэцэрлэгийн багш, соёлын ажилтнуудыг эчнээ, экстранат сургалтанд хамруулна. |
| | | 2.7.4. Англи хэлний багш нарын мэргэшлийг дээшлүүлэх зорилгоор Хүмүүнлэгийн ухааны их сургуультай хамтран магистрын сургалт хичээллүүлэх санаачлагыг дэмжинэ. |

| | | |
|---|---|---|
| 2.8 | Аймгийн хэмжээнд нэн шаардлагатай байгаа мэргэжлээр суралцах, орлого багатай өрхийн 50 хүртэлх оюутны сургалтын төлбөрийг орон нутгийн төсвөөс хариуцан гэрээгээр суралцуулна. | 2.8.1.Аймгийн хэмжээнд шаардлагатай байгаа нарийн мэргэжлийн боловсон хүчний захиалгыг үндэслэн тухайн мэргэжлээр суралцах сонирхолтой, тодорхой шаардлага хангасан амьдралын боломж муутай оюутантай орон нутагтаа эргэн ажиллах нөхцөлтэй гэрээ байгуулан, сургалтын төлбөрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх замаар жил бүр 10-15 оюутан сургах ба үүнээс 5 оюутныг цэцэрлэгийн багш, дуу хөгжмийн багшийн мэргэжлээр суралцуулна. |
| 2.9 | Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байр, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, засварлах ажлыг дэс дараатай хийж, сургуулийн ачааллыг багасгана. | 2.9.1. Биндэр суманд 920 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, Цэнхэрмандал, Норовлин сумдад сургуулийн барилгыг тус тус барина. |
| | | 2.9.2. Тэмүүжин ЦС-ийн спорт залны барилга барина. |
| | | 2.9.3. Батноров, Галшар, Бор-өндөр, Хэрлэн сумын Тэмүүжин ЦСургуулийн дотуур байрны барилга барин, цэвэр, бохир усан хангамжийн системийг сайжруулах арга хэмжээ авна. |
| | | 2.9.4. Баян-овоо, Дадал, Батширээт, Жаргалтхаан, Дархан, Баянмөнх сумд, Хэрлэн сумын 5-р багт цэцэрлэгийн барилга барьж, Баянхутаг, Мөрөн сумын цэцэрлэгийн барилгад их засвар хийнэ. |
| | | 2.9.5. Бор-өндөр хотын сургуулийн барилгын өргөтгөлийг гүйцээн, Баян-овоо, Хэрлэн сумын 4-р сургуулийн барилгад их засвар, Бэрхийн сургуулийн дээврийн засвар, Хэрлэн 1-р сургуулийн дотуур байранд өргөтгөл хийнэ. |
| | | 2.10.1. СӨБ-ийн хувилбарт сургалтын үйл ажиллагааг эрчимжүүлэхээс гадна баг бүрт "гэр "цэцэрлэг ажиллуулна. |

| | | |
|---|---|---|
| 2.1 | Боловсролыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний дагуу сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 75 хувьд, суурь боловсролын хамран сургалтыг 95,6 хувьд хүргэнэ. | 2.10.2. Сургууль завсардалтыг бүрэн арилгаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсрол олгох сургалтад тэгш хамруулах ажлыг зохион байгуулж, тухайн чиглэлийн багш нарыг жилд 2-оос доошгүй удаа сургалтанд хамруулна. |
| 2.11 | "Аварга тосон" рашаан сувиллын дэргэд " Багш нарын амралт" байгуулна. | 2.11.1. Багш нарын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Дэлгэрхаан суманд багш нарын амралтын газар байгуулна. |
| 2.12 | Ерөнхий боловсролын сургуулиудын байршил,хэв шинжийг орон нутгийн засаг захиргааны нэгжийн өөрчлөлттэй уялдуулан оновчтой тогтооно. | 2.12.1. Хэрлэн сумын Тахилгат тосгоны бага сургууль, дотуур байрыг засварлаж хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. |
| | | 2.12.2 Оторчдын хүүхдүүдийг орчин үеийн, стандартын шаардлагад нийцсэн дотуур байранд амьдарч, сурч хүмүүжих боломцоогоор хангана. |
| 2.13 | Хүүхдийн ордонд түшиглэн Хүүхдийн ардын урлагийн чуулга байгуулан ажиллуулна. | 2.13.1. Хүүхдийн чуулга байгуулж, улсын бүртгэлд бүртгүүлэн, ардын дуу, уртын дуу, богинын дуу,бүжгийн болон бусад ардын урлагийн дугуйлан хичээллүүлж, "Хан Хэнтийн хүүхдийн өдрүүд"-ийг УБ хотод зохион байгуулна. |

| | | |
|---|---|---|
| 2.14 | Математик болон байгалийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай цогцолбор сургуулийг аймгийн төвд байгуулна. | 2.14.1. Аймгийн төвд математик, байгалийн ухааны сургалттай цогцолбор сургуулийг байгуулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. |
| Соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг явуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх, соёлын үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах, ард түмн хэрэгжү | | |
| 2.15 | Соёл урлагийн байгууллагын ажилтнуудын мэргэшил, ур чадварыг сайжруулах, сумдын соёлын төвийг мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, мэргэжлийн хөгжмийн багшийн эзлэх хувийг 50-60 хувьд хүргэнэ | 2.15.1. Хөгжмийн багшийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг Хан Хэнтий чуулгыг түшиглэн зохион байгуулна. |
| | | 2.15.2. Соёлын төвүүдийг мэргэжлийн боловсон хүчнээр хангахад анхаарч Соёлын дээд сургууль болон эчнээ сургалтанд сургах ажлыг үе шаттай зохион байгуулж, жилд 5-аас доошгүй соёлын ажилтныг сургахад дэмжлэг үзүүлнэ. |
| 2.16 | Соёлын салбарын гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын соёл урлагийн байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага солилцуулах, гадаадад аялан тоглолт хийх санаачлагыг дэмжинэ | 2.16.1. Хан Хэнтий чуулгын уран бүтээлчдийн болон аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын тоглолтыг хөрш орнуудад зохион байгуулах мэргэжлийн чиглэлээр оюутан сургах, харилцан туршлага солилцох зэргээр хамтарч ажиллана. |
| 2.17 | Соёл урлагийн байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, орон нутгийн болон улсын чанартай уралдаан тэмцээнийг уламжлал болгохоос гадна нутгийн нэрт дуучид, уран бүтээлчдийн алдрыг тэмдэглэх, тэднийг алдаршуулах ажлыг зохионо. | 2.17.1. Сумдын соёлын төвүүдийн дунд "Сум сурталчилах өдөр"-ийг зохион байгуулж дүгнэнэ. |
| | | 2.17.2. "Аймаг сурталчилах өдөр"-ийг Улаанбаатар хотноо зохион байгуулна. |
| | | 2.17.3. Монгол улсын урлагийн гавьяат зүтгэлтэн Д.Санжаасүрэнгийн нэрэмжит "Зүүн Монгол угсаатны бүжиг"-ийн улсын уралдаан зохион байгуулна. |
| | | 2.17.4. Хэнтий нутгаас төрөн гарсан алдартай уран бүтээлчдийн алдрыг тэмдэглэх, тэдний тайлан тоглолтыг Өндөрхаан хотноо зохион байгуулна. |
| | | 2.18.1.Төв номын санг интернэтэд холбоход дэмжлэг үзүүлнэ. |

| | | |
|---|---|---|
| 2.18 | Аймгийн төв номын санг цахим мэдээллийн сүлжээнд холбон, сумын номын сангийн фондыг жил бүр баяжуулж, уншигчдын тоог нэмэгдүүлнэ. | 2.18.2.Номын фондыг жил бүр баяжуулна. |
| 2.19 | Орон нутгийн соёл урлагийн байгууллагын ажиллах орчин нөхцлийг стандартад нийцүүлэн сайжруулах, тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ, Өндөрхаан хотод 800 хүний суудалтай театрын барилга шинээр барина | 2.19.1. Хан Хэнтий чуулга, Цэнхэрмандал, Баян-Овоо, Дадал, Норовлин сумдын соёлын төвийн барилгыг шинээр барих, Хэрлэн-баян улаан, Дархан, Батширээт сумдын соёлын төвүүдийн барилгыг өргөтгөх, Төв номын сан, Гурван баян, Өмнөдэлгэр, Бэрх, Бор-Өндөр,Баянхутаг сумдын соёлын төвийн барилгад их засвар хийх асуудлыг ээлж дараатай шийднэ. |
| | | 2.19.2.Соёл урлагийн байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ. |
| | | 2.19.3. Аймгийн музейг дохиолол хамгаалал, хяналтын камертай болгож, музейн сан хөмрөгийн байрыг өргөтгөнө. |
| | | 2.19.4.Хүүхэд өсвөр үеийг музейн боловсрол олгох зорилгоор боловсролын танхим байгуулж, тохижуулна. |
| | ДУНДАЖ ХУВЬ | |

| ГУРАВ. ХҮН АМЫН ЭРҮҮЛ. МЭНДИЙГ ХАМГААЛАХ, ЭРҮҮЛ МЭ | | |
|---|---|---|
| Эмнэлэгийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой тогтолцоо бүрдүүлж, | | |
| 3.1 | Аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгыг бүрэн барьж ашиглалтанд оруулна. | 3.1.1 Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг гүйцээж ашиглалтанд оруулна. |
| 3.2 | Уламжлалт анагаах ухааны төв, нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгыг шинээр барьж ашиглалтанд оруулна. | 3.2.1 УАУТөвийн барилгыг шинээр барьж, орон нутгийн эмийн ургамал, өрнө дорны анагаах ухааны ололттой тал, судалгаа шинжилгээг хослуулан Монгол хүний бие мах бодийн онцлогт тохирсон уламжлалт эмчилгээ, сувилгааг түлхүү хөгжүүлнэ. |
| | | 3.3.1. Нэгдсэн эмнэлэгт **"Нярайн сэхээн амьдруулах тасаг"** байгуулан яаралтай тусламжийн багаж тоног төхөөрөмжөөр хангана. |
| | | |

| | | |
|---|---|---|
| | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан эх, нялхасын эндэгдлийг улсын дундаж түвшингээс бууруулахад чиглэсэн зохион байгуулалтын цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | 3.3.2. Эсэн мэнд амаржихуйн тусламж үйлчилгээг сайжруулж эх нялхасын эндэгдлийг улс аймгийн зорилтот түвшингээс бууруулна. |
| | | 3.3.3. Сумдад хүүхдийн хоол тэжээлийн болон чийрэгжүүлэлтийн сувиллын үйл ажиллагааг тогтмолжуулна.. |

| | | |
|---|---|---|
| 3.3 | | 3.3.4 Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлэх улмаар зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийг бууруулахад чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг өргөжүүлнэ. |
| | Эрүүл мэндийн салбарын эм хангамж, хүний нөөцийн талаар орон нутгийн онцлогт тохирсон бодлого хэрэгжүүлнэ. | 3.4.1. Эмч мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, сургах, давтан сургах, туршлага судлуулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэн ёс зүй, хариуцлагыг өндөржүүлнэ. |
| | | 3.4.2. Эмч дутагдалтай сумдыг эмчээр хангаж, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний тодорхой хэсгийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ. |

| | | |
|---|---|---|
| 3.4 | | 3.4.3 Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг сайжруулах асуудлыг шийдвэрлэнэ. |
| 3.5 | БГХӨСТөвийг зүүн бүсийн түшиц төв болгож, орчин үеийн оношилгооны багаж хэрэгсэл, сургалтын техник тоног төхөөрөмжөөр хангана | 3.5.1. Вирусын оношилгооны "ELIZA" аппарат, видео окуляр микроскопоор хангана. |
| | | 3.5.2. БГХӨСТөвийг дуудлагын "фургон" автомашинаар хангана. |
| 3.6 | Сумдын эмнэлгийг ЭХО аппаратаар хангахын зэрэгцээ алсын зайны оношилгооны нэгдсэн сүлжээнд үе шаттай холбоно. | 3.6.1. Баян-Овоо, Батноров, Баянхутаг, Галшар, Гурванбаян, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Мөрөн, Өлзийт, ХБУлаан, Тахилгат, Батширээт, Норовлин сумдыг ЭХО аппаратаар үе шаттай хангаж, эмч мэргэжилтнийг сургаж бэлтгэнэ. |
| | Улсын төсөв, төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр эмнэлгийн барилга шинээр барих, засварлах, түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийх, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ | 3.7.1.Халдвартын эмнэлэг, Өмнөдэлгэр сумын эмнэлэгийг шинээр барих асуудлыг ээлж дараатай шийдвэрлэнэ.. |
| | | 3.7.2.Аймгийн нэгдсэн эмнэлэг, Мөрөн Жаргалтхаан, Баян-Овоо, Дэлгэрхаан сум, Өлзийт, Тахилгат, Гурванбаян, Бор-Өндөр, тосгоны эмнэлгийн барилгуудад их засвар хийнэ. |
| | | 3.7.3.Аймгийн нэгдсэн эмнэлэг, БГХӨСТөв, УАУТөв, Баян-Адарга, Гурванбаян, Өлзийт, Батширээт, Баянмөнх, Дадал, Өмнөдэлгэр, Галшар, Дархан, Норовлин, Батноров сумын эмнэлгийн түргэн тусламжийн машины парк шинэчлэлт хийнэ. |

| | | |
|---|---|---|
| 3.7 | | 3.7.4.Эмнэлгүүдийг стандартын шаардлагад нийцсэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр үе шаттай хангана. |
| 3.8 | Нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлгүүдийг эмчилгээ оношилгооны техник хэрэгслээр тоноглогдсон автомашинаар хангана | 3.8.1.Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бор-Өндөрийн орон нутгийн нэгдсэн эмнэлэг, Биндэр, Бэрхийн сум дундын эмнэлэгүүдийг тоноглогдсон автомашинаар үе шаттай хангана |
| 3.9 | Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой эмзэг бүлгийн хүн амыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоонд үнэ төлбөргүй хамруулна. | 3.9.1. 2 жил тутамд нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг графикаар зохион байгуулна. |
| 3.1 | Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан "Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд багийн эмчийн унаа, хөдөлмөр хамгааллын хувцас, эм эмнэлгийн багаж хэрэгслээр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ | 3.10.1.Багийг эмчээр хангаж, ажлын нөхцлийг нь сайжруулан хөдөлмөр хамгааллын хувцас, эм багаж тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, унаагаар үе шаттай хангана |

| | | |
|---|---|---|
| 3.11 | Халдварт өвчний илрүүлэлтийг сайжруулах, уг өвчний гаралтанд нөлөөлж буй нийгэм эдийн засгийн сөрөг хүчин зүйлийг бууруулахад төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, хүрээлэн буй орчны бохирдлоос шалтгаалсан хүн амын өвчлөлийг бууруулна. | 3.11.1 Үндны ус, хөрсний бохирдлыг арилгах замаар эдгээрээс шалтгаалсан халдварт өвчний гаралтыг бууруулна. |
| | | 3.11.2 Халдварт өвчний илрүүлэлтийг сайжруулах, өвчний гаралт нэмэгдэх болон дэгдэлтийн үед шуурхай арга хэмжээ авах, нөөц чадавхийг бэхжүүлэх |
| | | 3.11.3 Айл өрх, албан байгууллагуудыг стандартын шаардлага хангасан бие засах газар, бохирын цооногтой болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. |

| | | |
|---|---|---|
| 3.12 | Сүрьеэ, ХДХВ/ДОХ өвчний тархалтаас сэргийлэн бэлгийн замаар дамжих халдварт өвчний өвчлөлийг бууруулна. | 3.12.1. Бэлгийн замаар дамжих халдвар болон сүрьеэ өвчнийг бүрэн илрүүлэхэд чиглэсэн нарийн мэргэжлийн эмчийн лабораторийн шинжилгээтэй үзлэгийг жил бүр зохион байгуулан илрүүлэлтийг нэмэгдүүлж эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авна |
| 3.13 | Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах, хангамжийг сайжруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 3.13.1. Өмнөдэлгэр сум, Бэрх тосгонд шинээр худаг гаргаж шүүлтүүр тавих замаар хүн амын усан хангамжийг сайжруулна. Мөн 3-аас доошгүй сумын эмнэлгийг гүний худагтай болгоно. |

| | | |
|---|---|---|
| 3.14 | Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, спортын материаллаг баазыг бэхжүүлэх ажлыг бүх талаар дэмжинэ. | 3.14.1. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх өсвөр залуу үеийнхний бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэхэд хувь хүн хамт олны идэвх санаачлагыг өрнүүлэх үйл ажиллагааг дэмжих |
| | | 3.14.2. Спорт цогцолборыг орчин үеийн спорт тоглоомын болон сургалтын техник хэрэгслээр хангаж, гадна талбайг иж бүрэн тохижуулна. Үүнд: электрон цаг, иж бүрэн узель аппаратур, спорт тоглоом, тамирчид зөөвөрлөх багтаамж бүхий автомашинтай болгоно. |
| | Биеийн тамир спортын волейбол, шатар, ширээний теннис, жудо зэрэг спортын 4 төрлөөр өсвөрийн шигшээ багийг бүрдүүлж, хичээллүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 3.15.1.Биеийн тамир спортын волейбол, шатар, ширээний теннис, жудо зэрэг спортын 4 төрлөөр өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг тогтмолжуулна. |

| | | |
|---|---|---|
| 3.15 | | 3.15.2.Өсвөрийн шигшээ багийн тамирчдын ур чадвар, арга барилыг дээшлүүлэх, дасгалжуулагчдыг харилцан туршлага солилцуулах, шинэ өсөх ирээдүйтэй тамирчдыг төрүүлэх зорилгоор **Үндэсний бөх, Жүдо бөх**ийн төрлөөр өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулна. |
| | Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Биеийн тамир спорт хорооны дэргэд "Хан Хэнтий-Аварга" бөхийн дэвжээ байгуулан үйл ажиллагааг нь тогтмолжуулна. | 3.16.1.Бөхийн спортын төрлүүдийг түлхүү хөгжүүлэх зорилгоор "**Хан Хэнтий-Аварга"** бөхийн дэвжээ байгуулан үйл ажиллагааг нь тогтмолжуулж, спорт хорооны "Б" заалыг бөхийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангана. |
| | | 3.16.2.Монгол улсын Засгийн газрын спортын их наадам зохион байгуулах тогтоолыг хэрэгжүүлэх, жил тутам их наадмын бүсийн болон шигшээ тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ. |

| | | |
|---|---|---|
| 3.16 | | 3.16.3.Биеийн тамир спортын салбарын боловсон хүчний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, туршлага солилцох бүсийн уулзалт, сургалт, семинарыг орон нутагт зохион байгуулна. |
| | ДУНДАЖ ХУВЬ | |
| ДӨРӨВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ БЭХ | | |
| Иргэдэд ойр, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн өөрчлөгдөж буй орчинд уян хатан зохицож чаддаг, идэвх | | |
| | Төрийн бүх шатны байгууллага, төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, хууль тогтоомжийг гажуудуулсан, хөшүүн хойрго хандсан аливаа илрэлийг таслан зогсоож тухай бүрд нь хариуцлага тооцно. | 4.1.1.Сумдын Засаг дарга нарын мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт үнэлгээ, шинжилгээ хийнэ. |
| | | 4.1.2.Иргэдэд өдөр тутам үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын ажлын тайланг жил бүр иргэдэд тавиулж, үнэлгээ авдаг болгож хэвшүүлнэ. |

| | | |
|---|---|---|
| | | 4.1.3.Төрийн албан хаагчийн ёс зүйг зөрчсөн, төрийн үйлчилгээнд хүнд суртал гаргасан албан хаагчийн талаар өргөдөл, гомдлыг хүлээн авах хайрцаг ажиллуулж тухай бүрт арга хэмжээ тооцно. |
| 4.1 | | 4.1.4.Улирал тутам 1-ээс доошгүй төсвийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт, үнэлгээ, шинжилгээ хийж, Засаг даргын зөвлөлд танилцуулж, ажилд нь үнэлэлт дүгнэлт өгүүлнэ. |
| | Иргэний нийгмийн байгууллагын зүгээс тавих хяналтыг хүчтэй болгож аймгийн Засаг даргын Тамгын газар дээр нээлттэй утас ажиллуулна. | 4.2.1.Иргэний нийгмийн байгууллагууд болон Авлигатай тэмцэх газартай хамтран төрийн бус байгууллагуудын сүлжээг байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг дэмжиж ажиллана. |

| | | |
|---|---|---|
| 4.2 | | 4.2.2.Аймгийн болон Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар дээр нээлттэй утас тогтмол ажиллуулж, иргэдээс гаргасан санал, гомдлын мөрөөр шуурхай арга хэмжээ авч ажиллана. |
| 4.3 | Нутгийн захиргааны байгууллагуудаас гаргасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд чирэгдэл учруулж буй эрх зүйн баримт бичгүүдийг хянан үзэж, шинэчлэх, хүчингүй болгох арга хэмжээ авна. | 4.3.1.Эрх зүйн баримт бичгүүдийг хянан үзэж, хууль тогтоомжинд нийцүүлэн шинэчлэх ба хүчингүй болгоно. |
| 4.4 | Аймагт хэрэгжиж байгаа болон хэрэгжих төсөл, хөтөлбөр, тендер шалгаруулалтыг ил тод нээлттэй байлгаж, хяналт тавих үйл ажиллагаанд нь иргэний нийгмийн байгууллагуудаас оролцуулж ажиллана. | 4.4.1.Аймагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн явц байдлыг мэдээллийн бүхий л хэлбэрээр тогтмол сурталчилж, шинээр эхлэх сонгон шалгаруулалтын бүрэлдэхүүнд иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг оролцуулж хэвшинэ. |

| | | |
|---|---|---|
| 4.5 | Аймгийн Засаг даргын дэргэдэх нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг иргэд, хөдөлмөрчдөд ил тод нээлттэй байлгаж, хийсэн ажлын тайлан, үр дүнг хэлэлцүүлж хэвшүүлнэ. | 4.5.1 Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнгийн талаарх тайланг жил тутам иргэд, хөдөлмөрчдөд тавиулж хэвшүүлнэ. |
| 4.6 | Бор-Өндөр, Бэрх хотын статусын асуудлыг шийдвэрлэнэ. | 4.6.1.Дархан, Батноров сумдын ИТХ-ын санал, санаачлагыг үндэслэн асуудлыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар оруулан Засгийн газарт уламжилж шийдвэрлүүлнэ. |
| | .“Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд бүх сумын багийн төвийг шинээр барих буюу сэргээн засварлаж, тохижилтыг бүрэн шийдвэрлэнэ. | 4.7.1.Сум бүрийг орон нутгийнхаа нөхцөлд тохирсон жишиг багтай болгоно. |
| | | 4.7.2.Багт байвал зохих техник хэрэгсэл, эд аж ахуйгаар хангана. |

| | | |
|---|---|---|
| 4.7 | | 4.7.3.Багт зайлшгүй шаардагдах хөрөнгийг сумын жил бүрийн төсөвт тусгаж багийн засаг даргын хяналт, саналаар зарцуулдаг болгоно.<br>4.7.4.Багийн Засаг дарга иргэддээ хүрч ажлаа явуулах нөхцөлийг бүрдүүлж унаагаар хангах.<br>4.7.5.Багийн Засаг дарга нарын давтан сургалтыг бүсчилэн явуулна. |
| 4.8 | Цэнхэрмандал, Дархан сумын Засаг даргын Тамгын газрын конторын барилгыг шинээр барина. | 4.8.1.Цэнхэрмандал сумын Засаг даргын Тамгын газрын конторын барилгыг шинээр барина.<br>4.8.2.Дархан сумын конторын барилгыг шинээр барина. |
| | | 4.9.1.Ой, хээрийн түймэр гарах магадлал өндөртэй Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн түймэр унтраах багаж хэрэгсэл үлээгч аппарат 2 ш, ус шүршигч 2 ширхэгээр тус тус хангана.<br>4.9.2.Ой, хээрийн түймэр гарах магадлал өндөртэй Дадал, Норовлин, Баян-Адарга, Жаргалтхаан сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн түймэр унтраах багаж хэрэгсэл үлээгч аппарат 2ш, ус шүршигч 2 тус тус хангана.<br>4.9.3.Сумын Онцгой комисс, Онцгой байдлын орон тооны бус штаб, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиудыг аранз, хувцсаар хангах, жигдрүүлэх. |

| | | |
|---|---|---|
| 4.9 | Аймаг, сумын Онцгой комисс, онцгой байдлын штаб, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний гамшигтай тэмцэх мэдлэг, дадлагыг дээшлүүлэх, хичээл сургалтыг үе шаттайгаар тасралтгүй зохион байгуулна. | 4.9.4.Аймаг сумын Онцгой комисс онцгой байдлын штаб, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн гамшигтай тэмцэх мэдлэг, дадлагыг дээшлүүлэх, хичээл сургалт, хяналт шалгалтыг үе шаттайгаар тасралтгүй зохион байгуулна. |
| | | 4.9.5.Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, команд штабын сургууль, үзүүлэх сургуулийг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулна. |
| | | 4.9.6. Засаг дарггын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 17 сум, 5 тосгонд зохион явуулна. |
| | | 4.10.1.Засаг даргын гамшигтай тэмцэх нөөц сангийн хөрөнгийг бүрдүүлж зориулалтын дагуу захиран зарцуулах. |

| | | |
|---|---|---|
| 4.1 | Гамшигтай тэмцэх нөөц сангийн хөрөнгийг бүрдүүлэх, нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана. | 4.10.2.Байгалийн аюулаас урьдчилан сэргийлэх хохирол нөхөх санг бүрдүүлэх гадаадын төсөл хөтөлбөр, тусламжийг энэ үйл ажиллагаанд чиглүүлэх, байгалийн гэнэтийн аюул, гамшигт нэрвэгдсэн малчид, иргэдэд учирсан хохирлын тодорхой хувийг нөхөн олгох, захиран зарцуулах. |
| 4.11 | Бор-Өндөр хотод Гал унтраах ангийг сэргээн байгуулж ажиллуулна. | 4.11.1.Бор-Өндөр хотын Гал унтраах ангид ажиллах боловсон хүчнийг сонгон шалгаруулах, сургах, дадлагажуулах. |
| | | 4.11.2.Бор-Өндөр хотын Гал унтраах ангийн барилгын засварын ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх. |
| | | 4.11.3.Бор-Өндөр хотын Гал унтраах ангийн автомашин техник, багаж хэрэгслийн засвар үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх. |
| | | 4.12.1.Улсын хөрөнгө оруулалтаар Өмнөдэлгэр суманд “Кабон” барилга бариулна. |

| | | |
|---|---|---|
| 4.12 | Улс, аймгийн хөрөнгө оруулалтаар 6-гаас доошгүй суманд хэсгийн төлөөлөгчийн “Кабон” барилга бариулна. | 4.12.2.Улсын хөрөнгө оруулалтаар Батширээт суманд “Кабон” барилга бариулна. |
| | | 4.12.3.Улсын хөрөнгө оруулалтаар Батноров суманд “Кабон” барилга бариулна. |
| | | 4.12.4.Улсын хөрөнгө оруулалтаар Норовлин суманд “Кабон” барилга бариулна. |
| | | 4.12.5.Аймгийн хөрөнгө оруулалтаар Галшар суманд “Кабон” барилга бариулна. |
| | | 4.12.6.Аймгийн хөрөнгө оруулалтаар Дадал суманд “Кабон” барилга бариулна. |
| 4.13 | Өндөрхаан хотод хөдөлгөөнт эргүүлийн тасаг ажиллуулж, эргүүлийн унааны асуудлыг шийдвэрлэнэ. | 4.13.1.Хөдөлгөөнт эргүүлийн 2 автомашины асуудлыг шийдвэрлэнэ. |
| 4.14 | Аймгийн Иргэний бүртгэлийн албаны мэдээллийн системийг Монгол Улсын иргэний бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбож, сумдад иргэний бүртгэлийн лавлагаа олгодог болох асуудлыг шийдвэрлэнэ. | 4.14.1.Аймгийн иргэний бүртгэлийн албаны мэдээллийн системийг Монгол Улсын иргэний бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбох. |
| | | 4.14.2.Сумдад иргэний бүртгэлийн лавлагаа олгодог болох асуудлыг шийдвэрлэнэ. |
| 4.15 | Төрийн архивын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, архивын тоо бүртгэл, эрэлт хайлтын үйл ажиллагааг боловсронгуй болгох, баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах. | 4.15.1.Төрийн архивын сан хөмрөгийн данс бүртгэлийг шинэчлэн сайжруулах, баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах стандартын нягтруулсан шүүгээ, тавиур, чийгшүүлэгч аппаратаар хангана. |
| | | 4.15.2.Сан хөмрөгийн данс бүртгэлийг мэдээллийн санд байрлуулах ажлыг үе шаттай зохион байгуулж хувилагч машин, сканнер, компьютер зэргээр хангана. |
| | Аймгийн Стандартчилал хэмжил зүйн төвийн лабораторыг эталон тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлнэ. | 4.16.1.Хэмжил зүйн лабораторийг усны тоолуур баталгаажуулах тоног төхөөрөмжөөр хангана. |

| | | |
|---|---|---|
| 4.17 | Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу иргэдээр хаалгах, тэдгээрийн хүчийг орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд дайчлах, цэргийн зориулалтаар ашиглаж байсан газар орныг тэсэрч дэлбэрэх галт хэрэгслийн үлдэгдлээс чөлөөлөх ажилд олон улсын байгууллага болон Зэвсэгт хүчний байгууллагатай хамтран ажиллана. | 4.17.1.Бүсчилсэн хөгжлийн бодлоготой нийцсэн орон нутгийн хамгаалалтын удирдлагын тогтолцоог төлөвшүүлж, түүнд орон нутгийн удирдлага, иргэдийг сургаж бэлтгэнэ. |
| | | 4.17.2.Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу иргэдээр хаалгах, нэгдсэн сургалтыг зохион байгуулж алба хааж буй иргэдийн хүчээр аймаг орон нутгийн тохижилт, цэцэрлэгжүүлэх ажил болон бүтээн байгуулалтын ажил хийлгэх. |
| | | 4.17.3.Цэргийн зориулалтаар ашиглаж байсан газар орныг тэсэрч дэлбэрэх галт хэрэгсэл /сум,мина/-ийн үлдэгдлээс чөлөөлөх, цэвэрлэхэд олон улсын байгууллага болон Зэвсэгт хүчнээс дэмжлэг авах. |

| | | |
|---|---|---|
| | Манай аймагтай хил залгаа орших Оросын Холбооны Улсын Байгалийн чанад дахь муж улс болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр, Хянган, Шилийн гол аймгуудтай тогтоосон харилцаа холбоог улам бататган хөгжүүлж, бүтээн байгуулалт, соёл, боловсрол, спорт, урлагийн чиглэлээр идэвхтэй хамтран ажиллана. | 4.18.1.Гадаад орнуудад мэргэжил дээшлүүлэх шинэ технологи, ажлын шинэ туршлага судлуулах арга хэмжээнд төрийн захиргааны байгууллагаас жилд 5-аас доошгүй албан хаагчдыг, бизнесийн байгууллагаас жилд 3-аас доошгүй хүнийг хамруулах. |
| | | 4.18.2.Ардын уламжлалт анагаах ухааны эмч, мэргэжилтэн харилцан солилцож, туршлага судлуулах. |
| | | 4.18.3.Хамтын ажиллагаатай муж, хотуудад жилд 5-аас доошгүй оюутан элсэн суралцуулах. |
| | | 4.18.4.Ерөнхий боловсролын сургуулиудын багш, сурагчид харилцан солилцох. |
| | | 4.18.5.Соёл, урлагийн тоглолт харилцан солилцох. |

| | | |
|---|---|---|
| 4.18 | | 4.18.6 Спортын багш, дасгалжуулагч, баг тамирчдыг харилцан солилцож, нөхөрсөг тоглолт зохион байгуулах. |
| | ДУНДАЖ ХУВЬ | |
| ТАВ. ДЭД БҮТЭЦ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ | | |
| Хөгжлийн хүрсэн түвшинг бататган дэд бүтэц, үйлдвэрлэлийг хөгжү | | |
| 5.1 | Өндөрхаан хотод Дулааны станц байгуулж, хотын бүх орон сууцыг хэрэглээний халуун усаар хангана, | 5.1.1 Техник эдийн засгийн үндэслэлийг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулах |
| | | 5.1.2 Зураг төслийг мэргэжлийн байгууллагуудтай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх |
| | | 5.1.3 Улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулж барилга угсралтын ажлыг эхлүүлэх |
| 5.2 | Өндөрхаан-Дадал чиглэлийн 270 км хатуу хучилттай автозамын ажлыг эхлүүлнэ. | 5.2.1 Өндөрхаан-Дадал чиглэлийн 270 км хатуу хучилттай автозамын зураг төслийг хийж гүйцэтгэх. |
| | | 5.2.2 Хатуу хучилттай автозамыг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна. |
| | | 5.2.3 Хатуу хучилттай автозамын ажлыг эхлүүлнэ |
| 5.3 | Өндөрхаан-Сүмбэрийн чиглэлийн авто замыг улсын хөрөнгө оруулалтаар барих ажлыг үргэлжлүүлнэ. | 5.3.1 Өндөрхаан-Сүмбэрийн чиглэлийн авто замыг улсын хөрөнгө оруулалтаар барих ажлыг үргэлжлүүлж барьж дуусгах |
| | Өндөрхаан хотын дотор 7.5 км автозамыг хатуу хучилттай болгож, гарц тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлнэ. | 5.4.1 Өндөрхаан хотын доторхи 7.5 км автозамыг хатуу хучилттай болгох |
| | | 5.4.2 Замын гарц тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлэх |

| | | |
|---|---|---|
| 5.4 | | 5.4.3 Замын хажуугаар мод тарьж хашаажуулан, өнгөт хавтангаар явган хүний зам тавина |
| 5.5 | Өндөрхаан хотын гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах төсөл боловсруулж, гэр хорооллын доторхи зам, цэвэр усны шугам, гэрэлтүүлэг зэрэг дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэнэ. | 5.5.1. 5000 м-ээс багагүй замын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, 1, 2, 3, 4, 5, 6-р багийн гэрэлтүүлгийг шинээр болон нэмж тавих |
| | | 5.5.2. Ундны усны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор уст цэгийг 2-с доошгүйгээр нэмэгдүүлэнэ. |
| | | 5.5.3. Ерөнхий төлөвлөгөөний дагуу замын нөхцөлийг сайжруулж, гэр хороололд сайжруулсан хайрган шороон зам тавина |
| 5.6 | Өндөрхаан хотод шинээр газар өмчлөн авсан иргэдийн цахилгаан хангамжийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 5.6.1 Өндөрхаан хотод шинээр газар өмчлөн авсан иргэдийн цахилгаан хангамжийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ. |
| 5.7 | Өмнөдэлгэр сумын Хурхын, Батширээт сумын Бархын голын гүүрүүдийг засварлана. | 5.7.1 Өмнөдэлгэр сумын Хурхын голын гүүрийг засварлана. |
| | | 5.7.2 Батширээт сумын Бархын голын гүүрүүдийг засварлана. |
| 5.8 | Баянмөнх сумын нутагт Хэрлэн гол дээр гүүр шинээр барина. | 5.8.1 Баянмөнх сумын нутагт Хэрлэн гол дээр гүүр шинээр барина. |
| 5.9 | Тахилгат тосгоныг эрчим хүчээр хангах асуудлыг шийдвэрлэнэ. | 5.9.1 Тахилгат тосгоныг эрчим хүчээр хангах асуудлыг шийдвэрлэнэ. |
| | Аялал жуулчлалын бүсийн дэд бүтцийг сайжруулах, Балданбэрэйвэн хийдийг сэргээн засварлах замаар жуулчдын тоог нэмэгдүүлэн Дадал, Дэлгэрхаан, [illegible] | 5.10.1 Балданбэрэйвэн хийдийг сэргээн засварлах |

| | | |
|---|---|---|
| 5.1 | жуулчлалын бүс болгон хөгжүүлнэ | 5.10.2 Аялал жуулчлалын маршрутыг хэд хэдэн чиглэлээр гаргах ба жуулчдын баазуудыг тохижуулах, аймаг, орон нутгийн сурталчилгааг сайжруулах |
| 5.11 | Бүс нутгийн тодорхой хэрэглээг хангахуйц сүүн бүтээгдэхүүний үйлдвэр барьж байгуулна | 5.11.1 Бүс нутгийн тодорхой хэрэглээг хангахуйц сүүний үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх |
| | | 5.11.2 Сүүний үйлдвэрийн барилгыг Өндөрхаан хотод барьж ашиглалтанд оруулна. |
| 5.12 | Өндөрхаан хотод махны анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр байгуулна | 5.12.1 Барилга болон тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг гүйцээж ашиглалтанд хүлээлгэж өгөх |
| | | 5.12.2 Мах, түүхий эдийн төвлөрсөн задгай захыг байгуулах |
| 5.13 | Мах, хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүнийг хадгалах стандарт, шаардлагыг хангасан агуулах шинээр байгуулна | 5.13.1 Мах, хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүнийг хадгалах стандарт, шаардлагыг хангасан агуулах шинээр байгуулах |
| | Жилд 10 сая хүртэл тоосго үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг түүхий эдийг нь түшиглүүлэн барьж байгуулна | 5.14.1 Тоосгоны үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, |
| | | 5.14.2 Жилд 10 сая хүртэл тоосго үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг ашиглалтанд оруулж, тоосго үйлдвэрлэж эхлэх |

| | | |
|---|---|---|
| 5.14 | | 5.14.3 Өндөрхаан хотод байрлах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тоосгоны үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэн жилд 3 сая ширхэг тоосго үйлдвэрлэдэг болгоно. |
| 5.15 | Одоо байгаа үйлдвэрлэлийн бааз дээрээ тулгуурлан орчин цагийн барилгын хэрэглээний шаардлага, хэрэглээг хангасан олон төрлийн цонх үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулна. | 5.15.1 Олон төрлийн цонх үйлдвэрлэх аж ахуйн нэгж, иргэдийг дэмжих, хөнгөлөлттэй зээлд хамруулах |
| 5.16 | Сумдад гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх жижиг аж ахуйн нэгжүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | 5.16.1 Гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх жижиг аж ахуйн нэгжүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлэх |
| | | 5.16.2 Өндөрхаан хотын гурилын үйлдвэрийн үйл ажиллагааг сэргээж, бусад сумдад гурилын үйлдвэр байгуулахыг дэмжиж ажиллана |
| 5.17 | Дадал суманд Зөгийн аж ахуй байгуулахыг дэмжинэ | 5.17.1 Дадал суманд зөгийн аж ахуй шинээр байгуулна. |
| | | 5.18.1 Сум бүрт хөгжлийн сан байгуулна. |

| | | |
|---|---|---|
| 5.18 | Жижиг дунд үйлдвэр, хоршоо, фермерийн аж ахуйг дэмжих зорилгоор сум бүрт хөгжлийн санг бий болгох ба техник тоног төхөөрөмжийг урт хугацаатай бага хүүтэй зээл, түрээс, лизингээр олгох үйлчилгээний хэлбэрийг дэмжиж ажиллана | 5.18.2 Техник, тоног төхөөрөмжийг урт хугацаатай, бага хүүтэй зээл, түрээс, лизингээр олгоход дэмжлэг үзүүлнэ. |
| | | 5.18.3 УИХ-ын гишүүдийн багцаас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн нэгж, иргэдэд дэмжлэг үзүүлэх |
| | | 5.18.4 Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин хөнгөлөлттэй зээлийг олгох |
| | | 5.18.5 2009-2012 онд хэрэгжүүлэх нийгмийн зөвшилцөлийн 3 талт хэлэлцээрийг байгуулах, хэлэлцээрийн биелэлтийг дүгнэх |
| 5.19 | Өндөрхаан хотод хувийн хөрөнгө оруулалтанд түшиглэсэн ариун цэврийн цаасны үйлдвэр байгуулна | 5.19.1 Техник эдийн засгийн үндэслэлээ боловсруулах, техинкийн нөхцөл авах зэрэгт нь шуурхай тусална. |
| | | 5.19.2 Үйлдвэрийг түүхий эдээр хангах, бүтээгдэхүүнээ борлуулахад нь дэмжлэг үзүүлнэ. |
| | | 5.20.1 Цементийн үйлдвэр барих газрын асуудлыг шийдвэрлэх |

| | | |
|---|---|---|
| 5.2 | Барилгын үйлдвэрлэлийн гол материал цементийн үйлдвэрийг байгуулна. | 5.20.2 Зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлийг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулах |
| | | 5.20.3 Улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулж барилга угсралтын ажлыг эхлүүлэх |
| 5.21 | ''Нэг сум-нэг бүтээгдэхүүн", ''Нэг тосгон-нэг бүтээгдэхүүн'' хөтөлбөрийг хэрэгжүүлэн аймгийн хэмжээний үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулж, сум бүрийг брэнд бүтээгдэхүүнтэй болгоно | 5.21.1 Аймгийн хэмжээний "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" шилдэг бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулна. |
| | | 5.21.2 Сум бүрийг өөрийн брэнд бүтээгдэхүүнтэй болгож, бүтээгдэхүүнээ сурталчилах, үйлдвэрлэлтээ нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ. |
| | Хот доторхи болон сум, хот хоорондын зорчигч тээвэр, шуудангийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, сумдын зорчигч хүргэлт, шуудан, хэвлэл хүргэлтийн давтамжийг 7 хоногт 2-оос доошгүй болгоно. | 5.22.1 Батширээт, Гурванбаян чиглэлийн зорчигч тээвэрлэлт, шуудан хүргэлтийн давтамжийг нэмэгдлүүлэх. |
| | | 5.22.2 Биндэр, Баян-Адарга чиглэлийн зорчигч тээвэрлэлт, шуудан хүргэлтийн давтамжийг нэмэгдүүлэх. |
| | | 5.22.3 Баянхутаг, Галшар чиглэлийн зорчигч тээвэрлэлт, шуудан хүргэлтийн давтамжийг нэмэгдүүлэх. |
| | | 5.22.4 Дэлгэрхаан, ХБУлаан чиглэлийн зорчигч тээвэрлэлт, шуудан хүргэлтийн |

| | | |
|---|---|---|
| 5.23 | Дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцож аймгийн хөгжлийн хурдцыг тодорхойлон ажиллана. | 5.23.1 Дотоодын нийт бүтээгдэхүүнийг тооцож аймгийн хөгжлийн хурдцыг тодорхойлно. |
| 5.24 | Орон нутгийн төсвийн хувьд бие даан санхүүжих орон нутгийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэх бодлого баримтлана. | 5.24.1 Орон нутгийн төсвийн хувьд бие даан санхүүжих орон нутгийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэх бодлого баримтлана. |
| 5.25 | Эдийн засгийн бүтцийг сайжруулан дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэр, үйлчилгээний салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлнэ | 5.25.1 Эдийн засгийн бүтцийг сайжруулан дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэр, үйлчилгээний салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлнэ. |
| 5.26 | Ашигт малтмалын боловсруулалтын түвшинг шат дараатай ахиулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ | 5.26.1 Ашигт малтмалын боловсруулалтын түвшинг шат дараатай ахиулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх |
| 5.27 | Жижиг дунд үйлдвэрлэгчдэд зөвлөгөө өгөх, дэмжиж туслах инкубатор байгуулж үйл ажиллагааг нь хэвшүүлнэ. | 5.27.1 Жижиг, дунд үйлдвэрлэгчдэд зөвлөгөө өгөх, дэмжиж туслах инкубатор байгуулж ажиллах |

| | | |
|---|---|---|
| 5.28 | Аймгийн 2009-2021 онд хөгжүүлэх урт хугацааны цогц бодлого боловсруулж аймгийн ИТХ-д хэлэлцүүлэн батлуулж мөрдөж ажиллах | 5.28.1 Аймгийг 2009-2021 онд хөгжүүлэх урт хугацааны цогц бодлого боловсруулан аймгийн ИТХ-д хэлэлцүүлэн батлуулж мөрдөж ажиллана. |
| | ДУНДАЖ ХУВЬ | |
| ЗУРГАА. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, БАЙГАЛ | | |
| Мал аж ахуйн үйлдвэрлэлд чанарын ахиц гаргаж, хүн ардаа экологийн цэвэр бүтээгдэхүүнээр бүрэн хангахад д | | |
| 6.1 | Эрчимжсэн болон хагас эрчимжсэн фермерийн загвар аж ахуйг шинээр байгуулах үүсгэл санаачлагыг дэмжиж, Өндөрхаан хотод сүүний чиглэлийн Симменталь, Хар тарлан үүлдрийн үнээ бүхий загвар аж ахуй, Өмнөдэлгэр, Норовлин, Баян-Адарга сумдад сүү -махны чиглэлийн үхрийн загвар аж ахуй байгуулна | 6.1.1 Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх сонирхолтой иргэд, аж ахуйн нэгжүүдээс сонгон шалгаруулж үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлнэ. |
| | | 6.1.2 Өндөрхаан хотод гахай, тахианы туслах аж ахуй байгуулна |
| | | 6.1.3 Загвар аж ахуйнуудыг ашиг шим өндөртэй хээлтүүлэгчийн гүн хөлдөөсөн үр олж авахад нь зуучлах, зохиомол хээлтүүлэг хийхэд нь мэргэжлийн туслалцаа үзүүлнэ. |
| | | 6.1.4 Өндөрхаан хотод сүүний чиглэлийн, Өмнөдэлгэр, Норовлин, Баян-Адарга сумдад сүү-махны чиглэлийн үхрийн загвар аж ахуй байгуулах санаачлагыг дэмжиж туслана. |

| | | |
|---|---|---|
| 6.2 | Сум бүрт ашиг шимийн үзүүлэлт өндөртэй цэвэр үүлдрийн хээлтүүлэгчийг үржүүлэх үржлийн аж ахуй байгуулах үүсгэл санаачилгыг дэмжиж, мах-ноосны чиглэлийн нарийвтар ноост Тал нутгийн цагаан үүлдрийн хонины удмын санг хамгаалах арга хэмжээ авна. | 6.2.1 Арвин ашиг шимт нутгийн шилдэг омог болон цэвэр эрлийз малын тоог нэмэгдүүлэх зорилгоор сум болгонд үржлийн аж ахуйн эхлэлийг тавина. |
| | | 6.2.2 Тал нутгийн цагаан үүлдрийн хонины удмын санг хамгаалах, ашиг шимийг сайжруулах үүднээс Орхон, Сэлэнгэ үүлдрийн нарийн, нарийвтар ноост хуцыг сайжруулагчаар ашиглах ажлыг зохион байгуулна. |
| 6.3 | Малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, үржлийн ажил үйлчилгээний хүртээмж, үр дүнг сайжруулах зорилгоор зохиомол хээлтүүлгийн байнгын болон явуулын цэгийг Дадал, Биндэр, Батширээт, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Норовлин, Хэрлэн сумдад байгуулна. | 6.3.1 Зохиомол хээлтүүлгийн байнгын болон явуулын цэгийг Дадал, Биндэр, Батширээт, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Норовлин, Хэрлэн сумдад байгуулна. |
| | Малын тэжээлийн үйлдвэрлэл, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс тариалан бүхий Өмнөдэлгэр, Хурх, Биндэр, Баян-Адарга, Норовлин сумдад малын тэжээлийн цех байгуулна | 6.4.1 Тариалан бүхий Өмнөдэлгэр, Хурх, Биндэр, Баян-Адарга, Норовлин сумдад малын тэжээлийн цех байгуулна. |
| | | 6.4.2 Бэлчээрийг нөхөн сэргээх, тарималжуулах үйл ажиллагааг идэвхжүүлэх эхлэлийг тавих |

| | | |
|---|---|---|
| 6.4 | | 6.4.3 Малчдын бүлэг, хоршоо, фермерүүд тэжээл тариалах, усалгаатай тариалалт эрхлэх нөхцлийг бүрдүүлнэ. |
| 6.5 | Арвин ашиг шимт нутгийн шилдэг омог болон цэвэр, эрлийз малын тоог нэмэгдүүлэх зорилгоор цөм сүрэг бүхий өрх айл, аж ахуйн нэгж байгууллагыг сум болгонд бий болгоход онцгойлон анхаарч, дэмжиж ажиллана. | 6.5.1 Цөм сүргийн болон сайжруулсан малын тоог нэмэгдүүлэх зорилгоор үржлийн сайжруулагчийн худалдаа солилцоог зохион байгуулах, өсвөр хээлтүүлэгч бойжуулах, борлуулах ажлыг тогтмолжуулна. |
| | | 6.5.2 Урьдчилан сэргийлэх тарилгын төлбөрийг орон нутгийн төсвөөс үргэлжлүүлэн олгуулна. |

| | | |
|---|---|---|
| 6.6 | Иргэд, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн оролцоотойгоор нуур, цөөрөм байгуулах, гар худаг гаргах үйл ажиллагааг дэмжиж инженерийн хийцтэй 60 худаг, уст цэгийг шинээр гарган, малчид иргэдийн оролцоотойгоор 100 энгийн уурхайн худаг гаргана. | 6.6.1 Инженерийн хийцтэй уст цэг 15-ийг жил бүр гаргана. |
| | | 6.6.2 Малчид иргэдийн оролцоотойгоор энгийн уурхайн худаг 25-аас доошгүйг жил бүр гаргуулах ба тэдгээрийг тодорхой үзүүлэлтээр шалгаруулан шагнаж байна. |
| 6.7 | "Атрын гурав дахь аян" тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор атаршсан нийт талбайн 50 хувийг эргэлтэнд оруулж тариалангийн талбайн хэмжээг 50.0 мян.га-д хүргэх ба парк шинэчлэлтийг ээлж дараатай хийнэ. | 6.7.1 Атаршсан талбайг сэргээн үр тарианы үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөдөлгөөн өрнүүлж, уг ажлыг эрхлэх иргэд, аж ахуйн нэгжид газар олгох асуудлыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах замаар чирэгдэлгүй шийдвэрлэж дэмжинэ. |
| | | 6.7.2 Тариалан бүхий аж ахуйн нэгж, иргэдийн ХАА-н техникийн парк шинэчлэлтийг зээлийн бодлогоор дэмжинэ. |
| | | 6.8.1 Тариалангийн талбайг услах бага, том оврын услалтын системүүдээр тариалан бүхий иргэд, аж ахуйн нэгжийг хангах бодлого барьж тусална. |

| | | |
|---|---|---|
| 6.8 | Өндөрхаан, Өмнөдэлгэр, Норовлин, Баян-Адарга, Биндэр сумдад усалгаатай газар тариаланг хөгжүүлэн усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 1000 га-д хүргэнэ | 6.8.2 Өндөрхаан, Өмнөдэлгэр, Норовлин, Баян-Адрага, Биндэр сумдад усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ. |
| 6.9 | Өрхийн орлогыг нэмэгдүүлэх “Ногоон хувьсгал” хөтөлбөрт хамрагдаж үйл ажиллагаа явуулж буй сум бүрт төмс, хүнсний ногооны үр, техник тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ | 6.9.1 Сумдын агропаркийг түшиглэн жимс, жимсгэний аж ахуй шинээр байгуулах үүсгэл санаачлагыг дэмжинэ |
| | | 6.9.2 Өндөрхаан хотод төмс, хүнсний ногоо борлуулах бөөний цэг шинээр байгуулна. |
| 6.1 | Хэрлэн суманд 1 га талбайд хүлэмжийн аж ахуй шинээр байгуулна | 6.10.1 Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хүлэмжийн аж ахуй эрхлэх зохимжтой газрыг төлөвлөн оруулж үйл ажиллагаа явуулах иргэдэд газрыг олгох ажлыг зохион байгуулна. |

| | | |
|---|---|---|
| 6.11 | Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг орон нутагт чанартай зохион байгуулж мал эмнэлэгийн оношлогоо, шинжилгээний лабораторийн чадавхийг дээшлүүэх, сумдын мал эмнэлэг, үржлийн нэгжийг хөрөнгө оуулалтаар дэмжих | 6.11.1 Мал эмнэлгийн оношлогооны техник ажиллагааг багасгах, орчин үеийн хурдавчилсан оношлуурыг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ. |
| | | 6.11.2 Төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд малын эрүүл мэндийг хамгаалах, зарим архаг халдварт өвчнүүдийг эрүүлжүүлэх үйл ажиллагааг бодит үр дүнд хүргэнэ. |
| | | 6.11.3 Аймгийн мал эмнэлгийн лабораторийг шинэ тоног төхөөрөмжөөр хангана. |
| | | 6.12.1 Малын орогномол өвчний шалтгааныг бүрэн тодруулна. |

| | | |
|---|---|---|
| 6.12 | Малын эндемик өвчний /орон нутгийн өвчин/ судалгааны ажлыг шат дараалан хийж, авах арга хэмжээний санал боловсруулах | 6.12.2 Малд шаардлагатай бичил элементийн дутагдлыг нөхөх эмчилгээний тэжээл бэлтгэх боломжийг судлаж, тоног төхөөрөмж суурилуулах, үйлдвэрлэж эхлэнэ. |
| | | 6.12.3 Бэлчээрийг сэлгээтэй, даацыг алдагдуулахгүй ашиглахад малчдын хүчийг чиглүүлнэ. |
| | | 6.12.4 Талхлагдсан бэлчээрийн судалгааг гаргаж нөхөн сэргээх ажлыг дэс дараатай авч хэрэгжүүлнэ. |
| | | 6.12.5 Төсөл, хөтөлбөр, гадны зээл тусламжаар бэлчээрийг нөхөн сэргээх үйл ажиллагааг эхлүүлнэ. |
| | Өндөрхаан хотын хог хаягдлын нэгдсэн цэгийн үйл ажиллагааг сайжруулах хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай аргаар булж устгах технологи хэрэгжүүлнэ. Хог хаягдал, хоёрдогч түүхий эдийн дахин боловсруулах жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ. | 6.13.1 Боловсруулж болох хуванцар, гялгар уут мэтийг ангилан ялгах үйл ажиллагааг бий болгож, боловсруулах бага оврын үйлдвэр байгуулна. |
| | | 6.13.2 Хог хаягдал түрж тэгшлэх, ландфил хийх, техник хэрэгсэл худалдан авна. |
| | | 6.13.3 Ландфил хийх бэлтгэл ажил хийнэ. /хамгаалах, булах, үер ус зайлуулах суваг хийх / |
| | | 6.13.4 Хог хаягдлын цэгийг хаягжуулах |

| | | |
|---|---|---|
| 6.13 | | 6.13.5 Хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагааны менежментийн асуудлыг сайжруулна.<br>6.13.6 Хог хаягдлын төвлөрсөн цэгийн зам талбай гаргах, эмнэлгийн болон тусгай ангилалын хог хаягдал устгах цэг, талбай барина.<br>6.13.7 Хог хаягдлын төвлөрсөн цэгийн хашаа барина.<br>6.13.8 Хогийн цэгийг тохижуулах, нөхөн сэргээлт хийх , ногоон байгууламж болон мод тарина. |
| 6.14 | Орон нутгийн экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад онцгой ач холбогдол бүхий улс, аймаг, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлнэ | 6.14.1 Улс, аймгийн хамгаалалтанд авах газруудын судалгааг сумдаас авч нутгийн өөрөө удирдах байгууллагаар шийдвэр гаргуулах, УИХ, Засгийн газарт тавьж шийдвэрлүүлнэ.<br>6.14.2 Улсын болон аймгийн тусгай хамгаалалтад ороогүй боловч шаардлагатай газруудыг орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гаргуулах, хилийн зааг, хамгаалалтын дэглэмийн биелэлтэд нь хяналт тавина. |
| 6.15 | Орон нутгийн хамгаалалттай газрын хамгаалалтыг сайжруулж байгаль хамгаалагчын орон тоог 50 хувиар нэмэгдүүлнэ | 6.15.1 Орон нутгийн хамгаалалттай газрын хамгаалалтын асуудлыг сайжруулах зорилгоор тухайн газрыг хариуцсан байгаль хамгаалагчийг нэмж ажиллуулна.<br>6.15.2 Байгаль хамгаалагчийн ажлыг удирдан чиглүүлэх, албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах, шаардлагатай бусад туслалцаа үзүүлэх |
| 6.16 | Ойн нөөцийг хамгаалах, ойжуулах, ойн аж ахуйн арга хэмжээг нэмэгдүүлж, жил бүр 200-га-аас доошгүй талбайд ойжуулалтын ажил хийлгэнэ | 6.16.1 Улсын төсөв болон аж ахуйн нэгжийн хөрөнгөөр жилд 200 га талбайд ойжуулалтын ажил хийлгэх ажлыг зохион байгуулна. |

| | | |
|---|---|---|
| 6.17 | Өндөрхаан хотоос зүүн тийш Хэрлэн голын хөндий дагуу төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалж байгаа иргэд, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжиж, цахилгааны найдвартай эх үүсвэрээр хангах шугам сүлжээг байгуулан, усалгаатай газар тариалан эрхлэх боломжтой “Цогцолбор аж ахуй” бий болгох замаар Өндөрхаан хотын иргэдийн хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | 6.17.1 Өндөрхаан хотоос зүүн тийш Хэрлэн голын хөндий дагуу төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалж байгаа иргэд, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжиж, цахилгааны найдвартай эх үүсвэрээр хангах шугам сүлжээг байгуулан, усалгаатай газар тариалан эрхлэх боломжтой “Цогцолбор аж ахуй” бий болгох замаар Өндөрхаан хотын иргэдийн хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ. |
| | | 6.17.2 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны эзэмшиж байгаа 10 га-г цахилгааны найдвартай эх үүсвэрээр хангаж гүний худаг гаргах, Хэрлэн голын салаанд 2 га талбайд жимс, жимсгэний суулгац тарьж бэлтгэн, хашаажуулах |
| 6.18 | Өндөрхаан хотод агаарын чанарын хяналтын харуул, байгаль орчны хяналтын лаборатори байгуулна | 6.18.1 Өндөрхаан хотод агаарын чанарын хяналтын харуул байгуулна. |
| | | 6.18.2 Байгаль орчны хяналтын лаборатори байгуулна. |
| 6.19 | Хэрлэнбаян-Улаан тосгонд Ус цаг уур, орчны шинжилгээний өртөөг шинээр байгуулна | 6.19.1 Хэрлэнбаян-Улаан тосгонд Ус цаг уур, орчны шинжилгээний өртөөг шинээр байгуулах |
| 6.2 | Цаг агаарт зориудаар нөлөөлөх газрын генератор Өмнөдэлгэр сумын нутагт байрлуулна | 6.20.1 Цаг агаарт зориудаар нөлөөлөх газрын генераторыг Өмнөдэлгэр сумын нутаг “Бурхан Халдун”-ы орчимд байрлуулна. |
| | | 6.21.1 Голын ай сав газар, ой, түүхт газруудад хайгуулын зөвшөөрөл олгохгүй. |

| | | |
|---|---|---|
| 6.21 | Алтны бага нөөцтэй шороон орд болон усны хагалбар, голын ай сав газар, ойн сан, байгалийн онцгой тогтоц бүхий газрууд, түүний хамгаалалтын бүсэд ашигт малтмал хайх, олборлохыг хориглох, байгаль орчин, хүний эрүүл мэндэд халтай арга технологиор уул уурхайн үйлдвэрлэл явуулахыг бүрэн зогсооно | 6.21.2 Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулна. |
| | | 6.21.3 Байгаль орчин, хүний эрүүл мэндэд халтай арга технологоор уул уурхайн үйлдвэрлэл явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагааг зогсоох арга хэмжээг авахын зэрэгцээ үйл ажиллагаа явуулдаггүй тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлнэ. |
| | ДУНДАЖ ХУВЬ | |
| | НИЙТ ДУНДАЖ ХУВЬ | |

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга А.Г.

/ 2009 оны жилийн эцсийн байдлаар /

| Биелэлт | 2009-2012 биелэлт % |
|---|---|
| IАХ, АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ | |
| йл өрхийн амьжиргааг дэмжих, ядуурлыг бууруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ. | |
| Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсээс 2009 онд явуулсан хүн амын ядуурлын түвшинг тогтоох судалгаанд аймгийн хэмжээнд 19511 өрх хамрагдаж, 7261 өрх буюу нийт өрхийн 37,2 хувь нь ядуу байна. | 50 |
| 2009 онд нийт 363 өрхийг ядуурлаас гаргахад бодит дэмжлэг үзүүллээ. Энэ зорилтын хүрээнд төсвийн болон,олон улсын хөтөлбөр,төсөл, аж ахуй нэгж байгууллагуудын дэмжлэгтэйгээр амьжиргааны түвшин доогуур өрхийн ажилгүй иргэдийг "Нэг өрх-нэг ажлын байр" хөтөлбөрт хамруулан байнгын болон түр ажлын байранд зуучлах, ахуйн үйлчилгээ, зочид буудал, цайны газар, оёдолын чиглэлээр мэргэжлийн сургалтанд хамруулах, бичил зээл олгох,хүнсний ногоо тариалахад нь зориулж ногооны үр олгох зэргээр 18,4 сая төгрөгийн санхүүжилт хийсэн байна. Мөн 31 өрхөд 1,6 сая төгрөгийн эсгий туурга олгов. Аймгийн хэмжээнд "Тогтвортой амьжиргаа-2" төслийн хүрээнд байгалийн гамшигт өртөж малгүй болсон 8 сумын 420 өрхөд 300,6 сая төгрөгийн 10020 толгой мал олгоод байна.Италийн төрийн бус Аифо байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа “Тэгш дүүрэн” хөтөлбөрийн хүрээнд Баянхутаг,Мөрөн,Биндэр,Хэрлэн сумын Тахилгат тосгоны хөгжлийн бэрхшээлтэй болон ядуу 35 өрхийг малжуулах төсөлд хамруулсан. | 30 |
| 2009 онд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Улаанбаатар хотын сургалтын төвүүдтэй хамтран сантехник,хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа,касс худалдагч,гар урлал,үсчин,мужаан,гар утасны засвар,нарийн боов,оёдол зүймэл, нарийн боовчин,байгууллага дээрх сургалт,малчдын болон аж ахуй эрхлэлтийн сургалт,үйлчилгээний ажилтан,бизнесээ хөгжүүл,агропарк ногоочдын сургалт,нийгмийн хамгаалал,бизнесийн хөгжлийг дэмжих сургалт,мэдээлэл зөвлөгөө өгөх сургалтанд 746 иргэн хамрагдаж, 75 хувь буюу 560 иргэн байнгын ажлын байртай болж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 53.9 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. | 50 |
| 2009 оны 5-р сард Аймгийн Хөдөлмөр,халамжийн үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран хорих ангид ял эдэлж буй 25 иргэнийг цахилгаанчин, гагнуурчны мэргэжил олгох 21 хоногийн сургалтанд хамруулж сертификат олгосон. | 30 |
| Аймгийн Хөдөлмөр,халамжийн үйлчилгээний хэлтсээр дамжуулан бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа иргэдээс 1471 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан. Хөдөлмөрийн багтаамж ихтэй нийтийг хамарсан ажилд 1042 иргэн хамрагдаж, дээрх иргэдэд 120.9 сая төгрөгийн цалин олгосон байна. | 50 |

| | |
|---|---|
| 2009 онд нийгмийн халамжийн тухай хуулинд заагдсаны дагуу 18-24 насны бүтэн өнчин өссөн 53 иргэн, байгалийн гамшиг, аюул осолд өртсөн 14 иргэнд, аймгийн ИТХ-ын болон Засаг даргын цохолтоор 7 иргэнд гэр авахад нь дэмжлэг болгож тус бүр 500,0 мянган төгрөг олгож, нийт 74 иргэнд гэртэй болоход нь дэмжлэг үзүүлээд байна.Мөн УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнийн багцаас 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 125 гэр олгоод байна. | 70 |
| Хэрлэн сумын хэмжээнд нийгмийн халамжийн тэтгэвэр,тэтгэмжид 601 хүн, нөхцөлт мөнгөн тэтгэмжид 509 хүн нийт 1110 хүн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байна. Нийгмийн халамжийн чиглэлээр олгож байгаа бусад хөнгөлөлтөд иргэд бүрэн хамрагдсан. | 50 |
| Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаагүй эмзэг бүлгийн өрхүүдэд түлээ нүүрсний хөнгөлөлтөнд хамрагдах иргэдийн судалгааг гаргаад байна. 200 метр куб түлээний модыг 125 иргэнд олгоод байна. | 30 |
| Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаагүй эмзэг бүлгийн өрхүүдийн хүүхдүүдийн судалгааг Хэрлэн сумын хэмжээнд гаргаж үзэхэд 2 хүүхэд дээрх үйлчилгээнд огт хамрагдаж байгаагүй болохыг тогтоосон. Эдгээр хүүхдийн нэг нь 18 насанд хүрч, халамжийн тухай хуулинд заагдсаны дагуу бүтэн өнчин өссөн иргэнд олгодог халамжийн үйлчилгээнд, үлдсэн нэг хүүхдийг хүүхдийн тэтгэмжийн үйлчилгээнд зохих журмын дагуу хамруулахаар болоод байна. | 50 |
| 2009 оны 10 дугаар сарын 05-нд Хэрлэн сумын эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд бүхий өрхийн ерөнхий боловсролын сургуулийн 200 хүүхдэд 3850.0 мянган төгрөгийн сурагчийн дүрэмт хувцас олгосон. | 30 |

| | |
|---|---|
| 40000 айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд тус аймгийн хэмжээнд баригдах 200 айлын орон сууц барих дэд төсөл боловсруулж хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу төлөвлөж газрын байршлыг тогтоон техникийн нөхцлийг олгон зураг төсөв нь хийгдсэн. 2005-2008 онд шинээр 12 айлын орон сууц баригдан 2 барилга байгууламжийн зориулалт өөрчлөн 20, 16, айлын орон сууц болгов. 2009 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Өндөрхаан хотод 21 айл, Бор-Өндөрийн Уулын баяжуулах үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар ажилчдын 21 айлын орон сууц тус тус баригдан ашиглалтад орж, Өндөрхаан хотод 78 айлын орон сууцны барилга угсралтын ажил хийгдэж байна. 40000 айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд тус аймгийн хэмжээнд баригдах 200 айлын орон сууц барих дэд төсөл болосруулж хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу төлөвлөж газрын байршлыг тогтоон техникийн нөхцлийг олгон зураг төсөв нь хийгдсэн. ОССКорпорациас Өндөрхаан хотод 20 айл, сумдад 4 айлын 12 сууц баригдахаар гүйцэтгэгчийн тендер зарлагдан 20 айлын орон сууцны барилгын ажил эхэлсэн боловч санхүүжилтгүйн улмаас барилгын ажил зогсоод байна . Нийтийн эзэмшлийн орон сууц барих хүсэлтэй аж ахуйн нэгжид төсөл сонгон шалгаруулалт болон дуудлага худалдаагаар олгох газрын төлөвлөгөөг гарган баталж, газрыг олгож байна. Мөн Бэрх хотод Захирагчийн ажлын алба, Сум дундын эмнэлэг, 70, 71 дүгээр байрны гадна дулааны шугамыг 33,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хэнтий-Ус ХХК шинэчилснээр халаалт хэвийн авах боломжтой боллоо. | 30 |
| 2009 онд хуучин хүүхдийн больницыг 17 айлын орон сууцны зориулалтаар засварлан аймгийн Засаг дарга "Хас банк"-ны удирдлагад санал тавьснаар тус банкнаас 5 иргэнд 33188 долларын орон сууц барьцаалсан зээлийг олгоод байна. | 30 |
| 2009 онд Тогтвортой амжиргаа-2 төслөөр Батширээт суманд 5,0 сая төгрөг,Дархан суманд 5,0 сая төгрөг, Галшар суманд 6,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгт хүрээлэнг байгуулж, Жаргалтхаан суманд Орон нутгийн Засаглалыг дэмжих хөтөлбөрийн хөрөнгө оруулалт 4,0 сая төгрөгөөр соёл амралтын хүрээлэнд явган хүний 2 урсгалтай зам, хөшөө, хаалга зэрэг тохижилтийн ажлууд хийв. Мөн Хэрлэн сумын 3-р багт орон нутгийн төсвийн 30,0 сая төгрөгийн хөрөнгөөр хүүхэд, залуучуудад зориулсан соёл амралтын хүрээлэнгийн 3,4 га газрыг хашаажуулж, 300 гаруй мод суулгаж, сагсан бөмбөгийн талбай болон зарим тоглоомуудыг суурилуулж тохижуулах ажил хийлээ. Уг соёл амралтын хүрээлэнгийн дэргэд цэвэр усны сүлжээнд холбогдсон худгийг шинээр байгуулж багийн иргэдийг ундны усаар хангаж байна. Батноров сум, Бэрх, Бор-Өндөр хотод хүүхэд, залуучуудын соёл амралтын хүрээлэнгийн газрын асуудлыг шийдвэрлэж, зураг төсвийг хийсэн. Өндөрхаан хотын төв цэцэрлэгт хүрээлэнд орон нутгийн төсвийн 23.8 сая төгрөгийн хөрөнгөөр усан оргилуур барьж хотын иргэдийн амрах орчинг сайжрууллаа | 30 |
| Хэрлэн сумын 3-р багт байгуулж буй соёл амралтын хүрээлэнд сагсан бөмбөгийн талбай, зарим тоглоомыг суулгаж, хөлбөмбөгийн талбайг засах ажил хийгдсэн. Хэрлэн сумын 5-р цэцэрлэгийн гадна хүүхдийн тоглоомын талбайг 3,0 сая төгрөгийн Тогтвортой амьжиргаа-2 төслийн хөрөнгөөр тохижууллаа. | 30 |

| | |
|---|---|
| 2009 оны 4 сард аймгийн Ахмадын хороотой хамтран аж ахуйн нэгж, байгууллагуудад нийгмийн халамжийн тухай хуулинд заасны дагуу "Ахмадын сан" байгуулан ажиллуулах талаарх албан бичгийг сумдын Засаг дарга нарт хүргүүлж зарим сум, албан байгууллагуудад , тухайлбал Баян-Адрага сум, аймгийн Аудитын газар ахмадын санг байгуулан ажиллуулж эхлээд байна. Баянмөнх сумын ахмадын хороонд сан байгуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 1,0 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэсэн.Дээрх ажлыг эхлүүлснээр ахмадуудын нийгмийн асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэх боломж нөхцөл бүрдэх юм. | 30 |
| | 2010 оноос |
| | 33.2 |

олаг, спортын талаар хэрэгжүүлэх зорилт

үйн хэм хэмжээг чанд мөрдүүлэн тэдний мэдлэг, чадвар, үлгэр дууриаллыг нэмэгдүүлж, хүүхдэд ээлтэй, ая тухтай сургалт хүмүүжлийн орчин бүрдүү

| | |
|---|---|
| Боловсролын мастер төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргын зөвлөлийн 2 удаагийн хэлэлцүүлэгт оруулж, аймгийн ИТХ-аар батлуулаад байна. | 100 |
| Аймгийн хэмжээнд сурлагын амжилт, чанарын дундаж үзүүлэлтийг жил бүр гарган мөрдөж ажиллахаар болоод байна. 2008-2009 оны хичээлийн жилд сурлагын амжилт, чанарын дундаж үзүүлэлтийг хичээл, анги, багш тус бүрээр нь гаргалаа. Шалгалтанд 14876 хүүхэд хамрагдаж, хөндлөнгийн үнэлгээгээр сурлагын амжилт 38,1, чанарын дундаж үзүүлэлт 23,4, стандарт хангалт 49.6 хувьтай байна. Хөндлөнгийн үнэлгээгээр аймгийн дундажийг гаргах нь учир дутагдалтай тул элсэлтийн шалгалтын үнэлгээгээр аймгийн дундажийг гарган улсын дундажтай харьцуулан мөрдөж ажиллахаар болоод байна. 2008-2009 оны хичээлийн жилд бага боловсролын дундаж 87,1 хувь, суурь боловсролын дундаж хувь 86,5%, бүрэн дунд боловсролын дундаж 87,5 хувь, сонгон болон мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр 87,3%-тай байна.Үүнийг улсын дундажтай харьцуулвал бага боловсрол 5,1%-иар их, суурь боловсрол 0,7%-иар бага, бүрэн дунд боловсрол 0,4%-иар их, мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр 0,6%-иар бага үзүүлэлттэй байна. | 100 |

| | |
|---|---|
| Боловсрол, соёлын нэгж байгууллага, багш, удирдах ажилтны үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж улмаар суралцагчдын сурлагын амжилтын аймгийн дундаж үзүүлэлтийг түүвэрчилсэн байдлаар тогтоож мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах зорилгоор бүх сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцахад Бор-Өндөр хотын сургууль 82.35 оноогоор 1-р байр эзэлж байхад ХБУ тосгоны сургууль 53.56 оноогоор хангалтгүй дүгнэгдлээ. 2008-2009 оны хичээлийн жилд сурагчдын авъяас чадварыг хөгжүүлэх, сурлагын амжилт, чанарыг нэмэгдүүлэх, удирдлагын менежмент, багш нарын мэдлэг чадварыг дээшлүүлэхийн тулд сурагчдад секц дугуйлан, мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалт хичээллүүлж, багш нарыг олон талт сургалт семинарт хамруулж ажилласны үр дүнд Хэрлэн нэгдүгээр сургууль “2008 оны улсын тэргүүний сургууль”-иар, Бор-Өндөр ЦС “Шилдэг менежменттэй топ” сургуулиар, Тэмүүжин ЦС суралдцагчдын авъяас чадварыг хөгжүүлэх секц дугуйлангийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан хамт олноор шалгарч БСШУЯ-ы “Батламж” 5 сая төгрөгөөр шагнагдлаа. Мөн үр бүтээлтэй ажилласан 37 багш төрийн дээд одон медалиар шагнагдлаа. | |
| Шинэ хичээлийн жилд аймгийн төвийн бүх сургуулиудын багш нарын хичээлийн бэлтгэл ажилтай 2 удаа танилцаж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | 30 |
| БСГ-т багшийн хөгжлийн төвийг нийт 2,9 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр тохижуулан үйл ажиллагаа явуулснаар багш болон бусад мэргэжлийн хүмүүст нийт 9 удаагийн сургалт 1 удаа видео хурал зохион байгуулсан. | 100 |
| Багшийн хөгжлийн төвийг түшиглэн 2009 онд 280 багшийг сургалтанд хамруулж мэргэжил боловсролыг дээшлүүлээд байна. | 30 |
| Электрон сургалтын арга зүй нэвтрүүлэх сургалтыг зохион байгуулж сургууль бүрт сургагч багш бэлтгэснээр тэд өөрсдийн сургуулийн багш нарт сургалт явуулан электрон сургалтын арга зүйг сургалтандаа амжилттай нэвтрүүлж байна. БСГ-аас бага ангийн багш нарын дунд "Мэдээлэл харилцааны технологийг сургалтанд ашиглах нь" сэдэвт уралдаан зарлаж дүгнэхэд Өмнөдэлгэр сумын сургууль 1-р байр, Тэмүүжин Цогцолбор сургууль 2-р байр, Жаргалтхаан сумын сургууль 3 байранд шалгарсан ба тус уралдаанд багш нарын сайшаалыг хүртсэн цахим үзүүлэнгийн санг сургууль бүрт хүргэхээр бэлтгэж байна."Мэдээлэл харилцааны технологийг сургалтанд ашиглах ахисан түвшний сургалт"-ыг төвлөрсөн хэлбэрээр зохион байгуулж 75 бага ангийн багш, сургалтын менежер, мэдээлэл зүйн багш нар хамрагдан, III шатны сургалтыг сургууль дээрээ зохион байгуулж нийт багш нарыг хамруулаад байна. | 30 |
| Одоогийн байдлаар 11 багш УБ болон Дорнод ДС-д цэцэрлэгийн багш, МУБИС-ийн СӨБ-ын багш бэлтгэх хөрвөх сургалтанд 6 багш, суралцаж байна.Одоогийн байдлаар цэцэрлэгийн мэргэжлийн багшийн хангалт 54,%-тай байна. | 30 |

| | |
|---|---|
| 2009-2010 оны хичээлийн жилд дунд, ахлах ангийн 7571 хүүхэд 362 компьютер сургалтанд ашиглаж байгаа ба нэг компьютерт 21 хүүхэд ногдож байна. Хан Хэнтий ЦС-д аймаг орон нутгаас иж бүрэн компьютерын кабинет байгуулж өгснөөр нийт сургалтанд ашиглах компьютерийн тоо 383 болж нэг компьютерт ногдох хүүхдийн тоо 19 боллоо.Аймгийн МСҮТөв нь өөрийн хөрөнгө оруулалтаар 40 компьютертэй мэдээлэл технологийн 2 кабинет байгуулан сургалт явуулж байна. | 0.3 |
| 2009 оны байдлаар 11 жилийн сургалттай сургуулиудад 10-15 компьютертай 9 кабинет, 9 жилийн сургуулиудад 10-15 компьютертай 5 кабинет хичээллэж байна. БСШУЯ-ы хөрөнгө оруулалтаар Тэмүүжин ЦС-д 20, Хэрлэн -1, 4-р сургуулиуудад тус бүр 10 компьютер хуваариласан. | 0.5 |
| Хүүхэд бүрт компьютер хөтөлбөрийн хүрээнд Хан Хэнтий Цогцолбор сургууль 330 компьютераар хангагдаж сургалтанд ашиглаж байна. БХХ, Азийн Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сумдын сургуулиудыг интернэтэд холбон цахим мэдээлэл ашиглахаас гадна Бор-Өндөр хот, Жаргалтхаан, Тэмүүжин ЦС цахим номын сантай болж үйл ажиллагаагаа явуулж байна. | 0.3 |
| АЗДТГ-аас санаачлан Хан Хэнтий Нутгийн Хамтын Хүч баг, Монголын тоглоомын холбоотой хамтран ажилгүй байгаа иргэдийг тоглоом наадгай хэрхэн хийх талаар сургалтанд хамруулан тэдний хийсэн бүтээгдэхүүнийг аймгийн нийт цэцэрлэгүүдэд зах зээлийн ханшаас бага үнээр улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн худалдан авах төлөвлөгөөтэй байна. Ингэснээр цэцэрлэгүүдийн тоглоом наадгайн хангамж нэмэгдэхээс гадна ажилгүйчүүдэд ажлын байр бий болгож өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой ажил болох юм.Энэ ажлын хүрээнд цэцэрлэгт зайлшгүй байх ёстой тоглоомын судалгаа, саналыг авч нэгтгэн урьдчилсан төлөвлөгөөг гаргаад байна.2008-2009 оны хичээлийн жилд Дэлхийн Зөн ОУБ-аас 2,8 сая төгрөгийн тоглоом наадгайгаар Өмнөдэлгэр, Биндэр сумын цэцэрлэгүүдийг хангаж,Тогтвортой амжиргаа төслийн хүрээнд Хэрлэн сумын 5-р цэцэрлэг, Галшар, Баян-овоо сумдын цэцэрлэгийн гаднах тоглоомын талбайд 15 сая төг, Батширээт сумын цэцэрлэгийн тоглоомонд 1,2 сая төгрөг, нийт 19 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.Дотор тоглоомын хангалт 25%, гадна тоглоомын хангалт 49%-тай байна. | 30 |
| БСГ, МХГ, АЗДТГ-аас Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллан "Үдийн хоол" болгох бэлтгэл ажил хангаж, заавар зөвлөмж өгч ажиллаж байгаа бөгөөд сургуулиуд 7 хоногийн 2-3 өдөрт халуун хоол өгч хэвшсэн. Тус хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлгээ хийхэд "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилт 80.5 хувьтай байсан ба Бор-Өндөр, Хан-Хэнтий цогцобор сургуулиудад хангалттай сайн хэрэгжүүлж байна. Аймгийн хэмжээнд 9 сургууль нь цайны газартай бөгөөд түүгээр дамжуулан үдийн цайгаар үйлчилж байна.Тогтвортой амжиргаа-2 төслөөр Баянмөнх, Норовлин сумдын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг 6,1 сая төгрөгөөр, Өмнөдэлгэр сумын сургуулийн дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмжийг 3,7 сая төгрөгөөр тус тус шинэчиллээ. | 30 |

| | |
|---|---|
| МСҮТ-ийн барилгад нийт 3.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдснаас 2009 онд 266,3 сая төгрөг төсөвлөгдөж барилгын суурийн ажил хийгдэж байна. | 30 |
| МСҮТөв нь гүн өрмийн 2 худаг гарган, худгийн барилга барьснаар ногооны газар, жимсний цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэнгээ услах арчлах бүрэн боломжтой болсон ба мод үржүүлгийн болон ногооны талбайтай болж эхний тариалалтыг хийгээд байна. Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 2 фермерийн аж ахуйтай хамтран ажиллаж, 30 хүүхэд дадлага хийн, мэргэжлийн туслалцаа үзүүлж байна. МСҮТ-өөс 100 сая төгрөгийн фермерийн аж ахуй байгуулах төсөл бичиж БСШУЯ- болон Мянганы сорилын санд хүргүүлсэн боловч хариу ирээгүй байна. Төрийн захиргааны төв байгууллагаас Монголын Мянганы Сорилтын сангийн Техникийн мэргэжлийн боловсрол сургалтын “Бодлого үйл ажиллагааны хүрээний шинэчлэл” дэд төсөл боловсруулж, Техник мэргэжлийн боловсролын сургалтын салбарын чадавхийг бэхжүүлэх, мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нь боловсролын энэ салбарын хөгжлийн бодлого, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна. | 30 |
| ХХҮХ, МСҮТ-ийн ажлын уялдааг сайжруулах талаар гэрээ байгуулан, бэлтгэж байгаа мэргэжлүүдээр дадлага хийлгэн үр дүнг тооцон ажиллахаас гадна Нийгмийн Хамгаалал Хөгжлийн Хөтөлбөр төслийн хүрээнд сургуулийн тоног төхөөрөмж, нөөц бололцоон дээр тулгуурлан иргэдэд мэргэжил олгох түр сургалт явуулж үр дүнд хүрч байна. 3-р улирлын байдлаар нийт төгсөгчдийн /240/ 63.5% нь аж ахуй нэгжид түр болон байнгын ажлын байраар хангагдаад байна.ХХҮХ-тэй хамтран сантехникийн 21 хоногийн түр сургалтыг 1 удаа зохион байгуулж 25 хүнийг хамруулаад байна. | 30 |
| Эхний ээлжинд лицей сургуулийг 2009-2010 оны хичээлийн жилд хичээллүүлэхээр багш нарын нөөц бүрдүүлэх ажлыг эхлүүлээд байна. | 10 |
| Соёл, урлагийн коллежийг Өндөрхаан хотод байгуулахаар Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 66 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын мөн өдрийн 169 дүгээр захирамжаар Тэмүүжин ЦС-ийн хичээлийн II байрны барилгыг "Урлагийн коллеж" байгуулахаар хүсэлт гаргасан "Идуган Энтертаймент" ХХК-д гэрээгээр эзэмшүүллээ. | 30 |
| 2009 онд 11 багш УБ хотод болон Дорнод аймагт цэцэрлэгийн багшийн мэргэжил олгох анхан шатны сургалтанд, хөрвөх багшийн сургалтанд 6, соёлын эчнээ сургалтанд 5 ажилтан хамрагдан суралцаж байна. Соёл урлагийн коллежийг Өндөрхаан хотод байгуулахаар болсон нь 2010 оноос эхлэн тус сургуульд урлаг, соёлын ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах боломжтой болж байна. | 30 |
| Англи хэлний багш нарын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх зорилгоор Хүмүүнлэгийн ухааны их сургуультай хамтран магистрын сургалтыг 2010 оны 1 дүгээр улирлаас эхлэн хичээллүүлэх гэж байгаагаас гадна бизнесийн удирдлага, боловсрол, соёл судлалаар магистрын сургалт хичээллүүлнэ.Одоогийн байдлаар 60 гаруй хүн бүртгүүлээд байна. | 100 |

| | |
|---|---|
| БСШУЯ-наас дэвшүүлэн тавьсан “Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах” зорилт, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2008 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан Аймгийн Засаг даргын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэргийг хэрэгжүүлэх зорилгоор "Сургалтын төлбөрийг орон нутгийн төсвөөс хариуцан гэрээгээр суралцуулах журам" батлагдаж 2009-2010 оны хичээлийн жилд сумдаас нийт 21 хүүхдийн материал ирснээс шалгуурт нийцсэн 4 оюутанд 2.7 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүллээ. | 30 |
| Биндэр суманд 1.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 920 хүүхдийн суудалтай сургуулийн шинэ барилгын ажил эхэлж 2009 онд 270.0 сая төгрөгийн барилга угсралтын ажил хийгдлээ. | 30 |
| Тэмүүжин цогцолбор сургуулийн спорт залны барилгыг " Бетон арматур" ХХК шинээр барьж ашиглалтад оруулаа | 100 |
| Бор-Өндөр хотын дотуур байрны барилгын явц 70%-тай байна. | 30 |
| 2009 онд Баян-Адрага, Баянмөнх суманд 75 ортой цэцэрлэгийн барилга тус тус баригдан ашиглалтанд орж, Батширээт суманд 75 ортой цэцэрлэгийн барилга баригдаж байна. Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгыг 50.0 сая төгрөгөөр засварлаж, Тогтвортой амжиргаа төсөл, Орон нутгийн засаглалыг дэмжих хөтөлбөрийн хөрөнгөөр Баянхутаг сумын цэцэрлэгийн барилгад 24 сая төгрөгийн их засварын ажил хийгдээд байна. | 50 |
| Бор-өндөр хотын сургуулийн барилгын өргөтгөл, дотуур байрны барилгад нийт 729,8 сая төгрөг батлагдснаас 2009 онд 479,8 сая төгрөг хувиарлагдан барилгын явц 70%-тай байна. Хэрлэн 1-р сургуулийн дотуур байрны 160 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай их засварын ажил дуусч ашиглалтанд ороод байна. Хэрлэн сумын 4-р сургуулийн барилгад дээврийн засварын ажил хийгдээд байна. | 50 |
| 2008-2009 оны хичээлийн жилд хувилбарт сургалтанд нийт 1129 хүүхэд хамрагдснаас 247 нь гэр цэцэрлэгт хамрагдаж, СӨБ-ын хамран сургалт 83,1%-д хүрсэн. 2009-2010 оны хичээлийн жилд хувилбарт сургалтанд нийт 1090 хүүхэд хамрагдснаас 26 гэр цэцэрлэгийн 50 бүлэг ажиллаж 539 хүүхдийг хамруулснаар СӨБ-ын хамран сургалт 84,5%-д хүрч, өмнөх оноос 1,4%-иар ахилаа.Суурь боловсролын хамрагдалт. 99,7 % тай байна. | 30 |

| | |
|---|---|
| Завсардалт хэдийгээр жил бүр буурч байгаа хэдий ч сургуулийн насны хүүхдийн биеийн эрүүл мэндийн байдал, амьдралын гачигдал, сурах сонирхолгүй зэргээс шалтгаалан огт завсардалтгүй болж чадахгүй байна. 2009-2010 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд 6-14 насны нийт 47 хүүхэд сургуулийн гадна байгаагаас 19 нь сургуульд огт сурдаггүй, 28 нь сургууль завсардсан хүүхдүүд байгаа бөгөөд үүнээс амьдралын гачигдлаас 27, сурах дургүйгээс 3, өвчний улмаас 1 хүүхэд сургууль завсардсан байна. Мөн дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд нийт 503 хүүхэд хамрагдсанаас бага боловсролд 256, суурь боловсролд 239, бүрэн дунд боловсролд 8 хүүхэд хамрагдаж байна. Сургуулийн насны 14785 суралцагчдаас 734 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байгаагаас 415 нь бага боловсрол, 259 нь суурь боловсрол, 60 хүүхэд бүрэн дунд боловсрол эзэмшихээр суралцаж байна. Дүйцсэн хөтөлбөрийн анхдугаар олимпиад, Албан бус боловсрол сурталчлах сарын аян, ур чадварын уралдаан зэргийг зохион байгуулснаас гадна багш нарыг чадваржуулах зүүн 4 аймгийн АББ-ын багш нарын сургалт, экскурс сургалт, БСГаас зохион байгуулсан модуль сургалт, | |
| БҮТ-өөс зохион байгуулсан шинжээч багш бэлтгэх сургалтуудад давхардсан тоогоор 77 багш хамрагдаж мэргэжил боловсролоо дээшлүүлээд байна. Хэрлэн 2, 3-р цэцэрлэгт хөгжлийн хүнд хэлбэрийн бэрхшээлтэй 25 хүүхэд сурч хүмүүжиж байна.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг багш нарын хувьд 3 удаагийн сургалтаар 11 багшийг хамруулаад байна. | 30 |
| Дэлгэрхаан суманд багш нарын амралтын газар байгуулах бэлтгэл хангаж сумын ИТХ-ын 2009 оны 06 сарын 24-ний өдрийн 03 тоот тогтоолоор газрын асуудлыг шийдвэрлэж, аймгийн зүгээс барилгын асуудлыг шийдвэрлэж өглөө. | 30 |
| Тахилгат тосгоны сургуулийг хэвийн ажиллах боломжоор хангахын тулд эхний ээлжинд 2010 оны 1 сарын 1-ээс эхлэн Тахилгат тосгонд Хэрлэн 5-р цэцэрлэгийн харъяа нэг бүлгийг нээн ажиллуулахаар 2010 оны төсвийн төсөлд тусгаад байна. | 30 |
| Оторчид ихээр суурьшдаг ХБУ тосгоны сургуулийн дотуур байрны шинэ барилгыг ХЯБХ-ийн хүрээнд 135 сая төгрөгөөр барихаар төлөвлөж, сантехникийн засвар, сургуультай холбох уурын зуухны холболт зэрэгт 2009 онд нийт 150сая төгрөг батлуулан барилгын ажлыг гүйцэтгэж ашиглалтад өглөө. | 100 |
| Хүүхдийн морин хуурын болон ардын хөгжмийн дугуйлан Хүүхдийн Төлөө Хэлтсийн дэргэд ажиллаж үйл ажиллагаа нь жилээс жилд сайжирч байна. Дэлхийн Зөн Олон Улсын Байгууллагын "Хан Хэнтий Хамтын Хүч" Төрийн бус байгууллагын 2 давхар байрыг Хүүхдийн ордны зориулалтаар шилжүүлэх бэлтгэл ажлын комисс аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан. Барилгын асуудал шийдэгдсэн нөхцөлд хүүхдийн ардын урлагийн болон хууль эрх зүйн мэдлэг олгох, авъяас чадварыг хөгжүүлэх чиглэлийн дугуйлангуудыг төрөлжүүлэн хичээллүүлэхээр төлөвлөөд байна. | 30 |

| | |
|---|---|
| Аймгийн төвд математик, байгалийн ухааны сургалттай цогцолбор сургуулийг байгуулахаар математикийн гүнзгийрүүлсэн сургалттай Тэмүүжин цогцолбор сургуулийг сонгож, 640 хүүхдийн суудалтай хичээлийн шинэ байр эзэмшүүлж, 2010 оноос байгалийн ухааны сургалтыг гүнзгийрүүлэн суралцуулах сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж байна. | 30 |

ий оюуны өв сан, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, сэргээн засварлах, ардын уламжлалт урлаг, зан үйлийг сурталчлан өвлүүлэх зорилтыг үлнэ.

| | |
|---|---|
| ЕБС-ийн дуу хөгжмийн багш нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 2009 оны 1 дүгээр сард Тэмүүжин цогцолбор сургуулийн дуу хөгжмийн багштай хамтран зохион байгуулж, аймгийн дуу хөгжмийн багш нарыг “CUBASE-SX” программ дээр ажиллах чадварыг эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулан зохион байгуулж нийт 22 багш нарыг хамрууллаа. | 30 |
| Хурх, Баян-Овоо, Галшар, Баян-Адарга, Цэнхэрмандал, Дэлгэрхаан сумдын соёлын төвийн хөгжим, дуу, бүжиг, номын санч нарын 10 соёлын ажилтан Соёлын дээд сургуулийн 21-45 хоногийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдлаа. Мөн Галшар сумын дуу хөгжмийн багш, Баян-Адарга сумын соёлын төвийн эрхлэгч нарт аймгийн Засаг даргын захирамжаар 600.0 төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүллээ. | 30 |
| Өвөр Монголын Өөртөө засах орны Хөлөн буйр хотын Зүүн хошууны урлагийн байгууллагатай Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулга хамтарч ажиллаж, айлчлан тоглолт хийх тухай албан тоот уламжилсны үр дүнд 2010 онд тоглолт зохион байгуулахаар боллоо.Мөн Хэрлэн 1р сургуулийн сурагч Япон улсын урлагийн их наадамд, Хан Хэнтий чуулгын 2 уран бүтээлч Англи улсад зохиогдсон ардын урлагийн наадамд тус тус амжилттай оролцлоо. | 30 |
| | |
| | |
| | |
| Монгол улсын ардын жүжигчин Ч.Шархүүхэний "Хорвоо дүүрэн дуу минь" уран бүтээлийн тайлан тоглолт болж тоглолтонд Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулыгн уран бүтээлчид оролцож аймгийн Засаг даргын нөөцөөс 500.0 мян төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 30 |
| Аймгийн төв номын санг интернэтэд холбосон. | 30 |

| | |
|---|---|
| Япон улсын буцалтгүй тусламжийн хүрээнд БСШУЯ-аас хэрэгжүүлж буй аймаг сумдын номын фондыг баяжуулах төсөл хэрэгжсэний үр дүнд 16 сум, 27 сургуулийн номын санд 67,7 сая төгрөгийн 7648 ширхэг номоор баяжигдлаа.үүнд: Нэг сумын соёлын төвийн номын санд 11.9 сая төгрөгийн 184 ш, ахлах сургуульд 1.2 сая төгрөгийн 158ш, дунд сургуульд 1.2 сая төгрөгийн 177 ш номоор тус тус баяжигдлаа.Мөн Засгийн газрыншугамаар 28.5 сая төгрөгийн 3066 ш ном ирснээс 12.5 сая төгрөгийн 1452 ш номыг сумын номын санд, 13.9 сая төгрөгийн 1508 ш номын сумдын сургуулиудад хуваарилснаар өмнөх оноос номын фондын баяжилт 2 дахин нэмэгдэж 7508 ширхэг номоор фондын баяжилт хийгдсэн байна. | 30 |
| 2009 онд Дэлгэрхаан суманд 312.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар соёл спортын төвийг шинээр барьж ашиглалтад оруулж 12.2 сая төгрөгийн номын сан, соелын төвийг ширээ, сандлаар хангалаа. Баян-Овоо сумын соёлын төвийн барилгыг барьж байна. Тогтвортой амьжиргаа-2 төслийн хүрээнд Биндэр сумын соёлын төвийн заал, бүжгийн танхимд 4,8 сая төг, Дадал сумын соёлын төвийн музейн дээврийн засварт 5,0 сая төгрөгийн барилга угсралтын ажил хийгдлээ. | 30 |
| Хөдөөгийн 22 соёлын төвүүдийг 1,3 сая төгрөгийн өртөг бүхий 4 төрлийн 80 гаруй үндэсний хөгжмийн зэмсгээр хангагдсаны зэрэгцээ УИХ-ын гишүүд болон бусад хандив тусламжаар сумдын 80 хувь нь аппаратур техник хэрэгслээр хангагдсан. Соёл урлагийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах болсонтой холбогдуулан сумдын соёлын төвийн тоног төхөөрөмжийн судалгааг гаргаснаар сумдын соёлын төвүүдэд компитер, принтер, канон, LCD проекторууд нэн шаардлагатай гэсэн судалгаа гарч байна. Одоогийн байдлаар соёл урлагийн байгууллагуудын 60%-д нь ажлын хэрэгцээний компьютер, принтер шаардлагатай байна. | 30 |
| Музейн хуучин дохиолол хамгаалалтыг сайжруулж, шинэчлэх талаар 2006 онд анх дохиолол холбосон компанид саналаа хүргүүлээд байна.Дохиоллын засвар үйлчилгээг хийлгэх, хяналтын камертай болох талаар төсвийн тодотголд санал оруулсан боловч санхүүжилт батлагдаж ирээгүй. Урьд нь дохиоллыг хийлгэсэн гэрээт компаниас мэргэжлийн хүнийг 7 сард авчирч газар дээр нь үзүүлж гэмтлийг шалгуулж оношлогоог тодруулсан. | 10 |
| Боловсролын танхимд шаардагдах хөрөнгийг 2010 оны төсөвт санал оруулж, танхимд хэрэглэгдэх Монгол улсын туг, далбаа, аймгийн туг, дуулал, хар, цагаан сүлд зэргийг бэлэн болгоод байна. | 10 |
| | |

ЭНДИЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ

эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, үйл ажиллагааны чадамжийг дээшлүүлнэ.

| | |
|---|---|
| ЭМСХ-2 төслийн санхүүжилтээр 738.0 сая төгрөгийн өртөгтэйгээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга шинээр баригдаж 2009 оны 7 дугаар сарын 8-нд ашиглалтанд авч Нэгдсэн эмнэлэгийн хүлээн авах, яаралтай тусламж, төрөх, эмэгтэйчүүд, мэс заслын I, II тасгуудад ажиллах нөхцөл боломж сайжирч үйлчлүүлэгчдэд тав тухтай орчин бүрдлээ. | 1 |
| ЭМЯамны 2010 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд УАУТөвийн шинэ барилгын 494.5 сая төгрөгийн төсөв тусгагдсан. УАУТөв нь 17 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж, 725 хүн хэвтэж эмчлүүлэн, зуны саам эмчилгээнд 247 хүн хүлээн авч сувилсан. Өөрийн орон нутагт ургадаг 13 нэр төрлийн эмийн ургамал түүж, эмийн түүхий эд бэлтгэн 25 нэр төрлийн эм тан хийж, 6 төрлийн засал эмчилгээнд хэрэглэж байна. Шинээр монгол төөнө,, цагаан гаргалга, халгайн ороолт, 5 рашаан зэрэг заслуудыг эмчилгээнд нэмж ашиглаж байна.Уламжлалт анагаах ухааны талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлсний 10 жилийн ойд зориулсан Монгол улсын уламжлалт анагаах ухааны анхдугаар чуулганд аймгаас нийт 15 төлөөлөгч оролцлоо. Мөн Мөрөн, Өмнөдэлгэр сумын эмнэлгүүдэд "Уламжлалт анагаах ухааныг дэлгэрүүлэх" төсөл хэрэгжиж байгаа бөгөөд 2010 онд Хэрлэн, Баянмөнх, Дархан суманд хэрэгжүүлэхээр шийдвэрлүүлэв. | 30 |
| Нярайн эмчилгээний өрөөнд ЭМСХ-2 төсөл, Дэлхийн зөн, УИХурлын гишүүн Д.Арвин, Гандантэгчилэн хийдийн хандив, тусламжаар амьсгалын аппарат 1, нярайн пульсоксиметр 1, тарилгын гуурс тавих автомат шахуургын аппарат 1, инкубатор 3, дулаацуулах ширээ 2, нярайн амбу 2, гэрэл эмчилгээ-хүчилтөрөгчийн концентратор, хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч 1, дуслын автомат шахуурга 1, цахилгаан отсос 1 зэрэг тоног төхөөрөмжөөр хангагдлаа. | 0.3 |
| 2009 онд аймгийн хэмжээнд 2 эх эндсэн бөгөөд ЭМГазар “Эх барихын ноцтой хүндрэл”, “Хүүхдийн эндэгдлийг бууруулах”-асуудлыг шуурхай зөвлөгөөнөөр хэлэлцэж нэгдсэн зөвлөмж гаргаж сум, өрх, нэгдсэн эмнэлгийн удирдлагад үүрэг болгож, ЭМГ-ын даргын 06 тоот тушаалийн дагуу сум, өрх болон мэргэжлийн багийн эмч нарын жирэмсэн, хүүхэд нэг бүрт тавих хяналтыг чанаржуулах арга хэмжээ авч ажиллаж байна. 2009 оны 1-р улиралд сумдын эмнэлэгийн санхүүжилтээр нарийн мэргэжлийн эмч нарын баг бүх сумдад ажиллаж 510 жирэмсэн эхчүүдийг үзэж, шинжилгээнд хамруулан, эрхтэн тогтолцооны эмгэгтэй жирэмсэнг эмчлэн, эрсдэлтэй жирэмснийг шилжүүлэн ажилласнаар жирэмслэлт, төрөлтийн хүндрэл 7.8 хувиар буурсан байна. | |

| | |
|---|---|
| Хүүхдийн эндэгдлийн тохиолдол бүрийг холбогдох сумдын эмч нарыг оролцуулан хэлэлцэж дүгнэлт гарган ажилллаж байна. Нярайн эндэгдлийг ЭНЭШТөвийн эх барихын клиникийн эмч нартай хамтран судалсан. Хүүхдийн өвчний цогц менежементийн эмнэлзүйн шинэчилсэн 40 цагийн сургалтанд 4 эмч хамрагдаж, өрх, сумын эмч нарт шинэ мэдээлэл хийж, ханын хүснэгтийг олгосон. "Хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж, эрэмблэн ангилалт" сэдвээр сумдын эмч нарт сургалт зохион байгуулсан. Нярайн эмч 1, сувилагч-1, хүүхдийн сэхээний сувилагч-1-ийг мэргэжил олгох сургалтанд хамруулсан. Сум, өрхийн эмнэлгүүдэд 4 удаа ХӨЦМ-ийн тандалт хийсэн. Хэрлэн сумын өрхийн эмнэлгүүдэд хүүхэд болон эх барихын эмч нар хуваарь гарган үзлэг хийж байна. Батширээт, Галшар, Баян-Адрага сумдад хүүхдийн эмч нарын баг ажиллаж үзлэг хийж зөвлөгөө өгсөн. | |
| "Эхийн сүүгээр хооллохыг дэмжих" дэлхийн 7 хоног сэдэвт ажлын хүрээнд 60 эхчүүдэд өртөөчилсөн сургалт зохион байгуулж, 55 ээжид хүүхдийн нэмэгдэл хоол бэлтгэх, 45 ээжийг сургагч багшаар бэлтгэсэн. "Бага насны хүүхдийн хоол тэжээл--Эрүүл мэнд" үндэсний сургалтанд ЭМГ-ын орлогч, хүүхэд өсвөр үеийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн нар хамрагдаж, орон нутгийн сургалтын төлөвлөгөө боловсруулан сургалтыг эхлүүлээд байна. 2009 оны байдлаар 1560 эх төрсөн нь 2008 оны мөн үеэс 7.6 хувь буюу 196 төрөлтөөр өссөн байна. Шинээр хяналтанд 1636 эхийг авснаас 83.0 хувь нь эхний 3 сартайд хяналтанд орсон байна. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 29.2 промил байгаа нь өнгөрсөн оноос 1.53 промилоор өссөн. Улсын дундаж 19.4. байна. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 31.74 байгаа нь өнгөрсөн оноос 5.63 промилоор буурсан байна. Улсын дундаж 22.8 промиль. | 0.1 |
| 2009 онд 22 суманд 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээл, чийрэгжүүлэлт, саам эмчилгээний сувилалыг 2-3 ээлжээр ажиллуулж нийт 336 хүүхдийг хамруулан хүүхдүүдийг нар ус, агаараар чийрэгжүүлэн, иллэг хийж, эцэг эхчүүдэд гэрийн нөхцөлд нэмэгдэл хоол хийх аргачлалыг зааж, өөрсдөөр нь дадлага хийлгэлээ. Сувилалд хамрагдсан хүүхдүүдийн 78,3% нь жин нэмэгдэж, 62,2% нь хоолны дуршил сайжирч, 42,7%-д нь сульдаагийн зарим шинжүүд арилж, 24,8%-д нь цус багадалт арилсан. Сургалтанд хамрагдсан эхчүүдийн мэдлэгийн түвшин сургалтын өмнөх үеийнхээс 32,6%-иар нэмэгдсэн. 8 суманд хүүхдийн чийрэгжүүлэлтийн талбайг засаж, тохижуулсан. Бэрх, Дэлгэрхаан, ХБУлаан, Батноров, Баянхутаг, Өлзийт, Гурванбаян, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр сумдад энэ үйл ажиллагаа тогтмолжсон нь хүүхдийн өвчлөл эндэгдлийг бууруулахад тодорхой үр дүнгээ өгч байна. | 0.3 |

| | |
|---|---|
| Засгийн газрын 224 дүгээр тогтоолын дагуу сургалтын нэгдсэн төлөвлөгөө гаргаж олон нийтийг хамарсан 11 сэдэвт арга хэмжээг 21638 хүнд, зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагааг 5 сэдэвт сургалтыг 268 хүнд, олон нийтэд чиглэсэн 7 сэдэвт сургалтыг 9432 хүнд хийгээд байна. Орон нутгийн Сан бүрд телевиз, Баян-Эрдэс FM радиотой гэрээ байгуулан ажиллаж байна. Сан бүрд ОСТВ-ээр “Манлайлаж явсныг мартахгүй”, “Тэр л үед”, “Хишиг өдөр”, “Өрхийн эмнэлгийн тусламж үйлчилгээ” /4 цуврал нэвтрүүлэг/," Судасны хатуурлаас сэргийлье", "Гараа хархэн зөв угаах вэ?", "Томуугаас сэргийлье","Тарваган тахлаас сэргийлье","Залуу донорын эгнээнд нэгдэцгээе","Халдварт шар өвчнөөс сэргийлье", " Томуугийн цар тахал" /цуврал нэвтрүүлэг/ зэрэг сэдвээр нийт 9 цаг 10 минутын нэвтрүүлэг, 3 цаг 20 минутын зөвлөмж, мэдээнүүдийг цаг тухайд нь шуурхай мэдээлж, шууд ярилцлага өгч байсан. Баян-Эрдэс FM радиогоор “Эрүүл мэндийн таван хором” нэвтрүүлгээр 30 гаруй сэдвээр 7 хоногийн 1.3.5 дахь өдрүүдийн 10, 15, 22 цагуудаас тогтмол явуулж, нийт 10 цаг 45 минутын зөвлөмж, мэдээ, ярилцлагыг явуулсан байна. Мөн 17 сэдвээр мэдээлэл боловсруулж, олшруулан 13680 ш гарын авлага материал тараасан. | 0.3 |
| Эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн чадавхийг дээшлүүлэхээр Жаргалтхаан сумын эмч мэдрэлийн эмчийн, Баян-Адрага сумын эмч хүүхдийн мэргэжлийн чиглэлээр тус тус суралцаж байна. Төрийн санхүүжилтээр хүүхэд, гэмтэл, эмгэг судлаач болон нярайн эмчийг мэргэжил олгох, 5 их эмч, 5 сувилагч мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаад байна. Ахмад настаны сувилагчийг мэргэшүүлэх 1 сарын сургалтанд хамруулж байна. ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг ЭМГазраас мэргэжилтэн урьж ирүүлэн "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй" сэдэвт сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 380 гаруй мэргэжилтнийг хамруулсан.Богино хэмжээний сургалтуудад нийт давхардсан тоогоор 565 гаруй эмч, мэргэжилтнүүд хамрагдсан. | 0.3 |
| Их эмчгүй байсан Галшар суманд 1 их эмч, Биндэр суманд мэс заслын эмч, НЭ-ийн ахмадын кабинетэд 1 эмч, 4 суманд багийн бага эмчийг томилон ажиллуулав. 2007 онд төгссөн дадлагажигч 21 их эмчээс суманд 12, өрхийн эмнэлэгт 3, БГХӨСТ-д 1, 2008 онд төгссөн 7 дадлагажигчаас суманд 5, УАУТ-д 1, өрхийн эмнэлэгт 1 эмчийг томилсон. Сумдын их эмч нарыг 14 хоногоор графикийн дагуу, эх баригч нарыг 7 хоногоор аймгийн НЭ-ийн төрөх болон хүүхдийн тасагт дадлагажуулах сургалтанд хамруулж байна. Мөрөн, Дэлгэрхаан сумын эмнэлгийн их эмч нар шинэ орон сууцаар хангагдсан ба ХБУлаан тосгоны эмчид хүүхдийн чийрэгжүүлэлтийн сувилал ажиллуулах гэр хүссэн тул 500.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 0.3 |

| | |
|---|---|
| Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ЭМГазар, сумын Засаг дарга, сумын эмнэлэг, ЭЭСангийн эрхлэгч нартай 4-талт гэрээ байгуулан ажиллаж байна. МУЗГ-ын 50 дугаар тогтоолын дагуу өрхийн эмнэлэг, ЭЭСангийн хөрөнгийг орон нутгийн өмчлөлд бүртгэх талаар Аймгийн ИТХТ-ийн тогтоол гаргуулсан. Удирдамжийн дагуу “Эм хангамжийн байгууллага”-уудын MNS 5260:2008, MNS 5376:2004, MNS 5530:2005 стандартын хэрэгжилтийн байдалтай танилцаж “Эмийн улсын бүртгэлийн өнөөгийн байдал” , “Агуулах түүнд тавигдах шаардлага” зэрэг сэдвээр мэдээлэл өгсөн. Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж хувийн эмийн сангуудын эздүүдтэй уулзаж санал солилцож эм зүйчийн удирдлаган дор ажиллах талаар зөвлөмж өгсөн. | 0.3 |
| Холбогдох хөрөнгө оруулалтын талаархи саналыг ЭМЯ-ны сайдын баг аймагт ирэхэд танилцуулж уламжилсан ба ЭМЯаманд 2 удаа албан бичгээр санал хүргүүлсэн. ЭМЯамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын 5/3442 тоот албан бичгээр 2010 онд шийдвэрлэх асуудлын судалгаанд авсан тухай хариу ирүүлсэн. | 10 |
| Хугацаа болоогүй | 2012 оноос |
| Норовлин, Батширээт сумдад Эхо аппарат олгох тухай Эрүүл мэндийн сайдын тушаал гарч олгохоор шийдвэрлэсэн. Норовлин сумын эмчийг дүрс оношилгооны 3 сарын мэргэжил олгох курст суралцуулж төгсгөсөн. ЭМЯ, НҮБ ХАС - НҮЭМ (MNG4R31C) төслийн санхүүжилтээр аймгийн нэгдсэн эмнэлэгт 19571.8 төгрөгийн өртөг бүхий ЭХО аппаратаар хангагдлаа. | 0.3 |
| ЭМЯамны 2010 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд санал хүргүүлснээр 10 ортой Өмнөдэлгэр сумын эмнэлгийн шинэ барилга 330.2 сая төгрөг, аймгийн 30 ортой Халдвартын эмнэлэг 719.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр шинээр баригдахаар шийдэгдсэнээс 2010 онд 400.0 сая төгрөгтусгагдаж батлагдсан. | 30 |
| 2009 онд улсын төсвийн санхүүжилтээр Бор-Өндөрийн орон нутгийн нэгдсэн эмнэлэгт 70,0 сая төгрөгийн их засвар хийгдсэн. Нэгдсэн эмнэлэг өөрийн хөрөнгөөр 1.7 сая төгрөгийн урсгал засвар хийсэн. Жаргалтхаан сумын эмнэлэгт 70.0 сая төгрөгийн өртөгтэй их засвар хийх, аян-Овоо сумын эмнэлгийн зураг төслийн зардлын хөрөнгө 2010 оны хөрөнгө оруулалтанд туссан. | 0.3 |
| ЭМГ-ын даргын 36 тоот тушаалаар УИХ-ын гишүүн Д. Арвиний хандивласан Япон улсад үйлдвэрлэсэн нэг бүр нь 7.0 сая төгрөгийн өртөгтэй SUZUKISWIFT, TOYOTA SPRINTEP, TOYOTA COROLLA маркийн автомашинуудыг ЭМГазар, Оюуны шим, Ач манал, Хэрлэн Дом өрхийн эмнэлгүүдэд хуваарилж үндсэн хөрөнгийн бүртгэлд авч ашиглалтанд хяналт тавин ажиллаж байна. ЭМЯамны хөрөнгө оруулалтаар Баян-Адарга, Гурванбаян, Баянмөнх сумын эмнэлэг УАЗ 469 машинаар, нэгдсэн эмнэлэг фургон автомашинаар хангагдлаа. | 0.3 |

| | |
|---|---|
| ЭМСХ-2 төслийн хүрээнд Нэгдсэн эмнэлэг флюр аппарат, 95.5 сая төгрөгийн өртөг бүхий дезкамер ариутгах төхөөрөмж, угаалгын болон гал тогооны иж бүрдэл зэрэг 4 төрлийн багаж тоног төхөөрөмжөөр хангагдаж үйлчилгээний ажилчдын ажиллах нөхцөл боломж сайжирлаа. Мөн "Шувууны томуу, хүний томуутай тэмцэх, сэргийлэх чадавхийг сайжруулах" төслөөс 1, АЗДТГазраас 1 компьютерээр хангагдсан. ДЗОУБ-ын санхүүжилтээр 7.5 сая төгрөгийн төсөл бичиж өвчтөний ор, эмчийн ширээ сандал, зөөврийн болон суурин кварц, дуслын хөл, хамгаалах хувцас, хүлээлгийн сандал, эмийн шүүгээ, 20 хөнжил, 40 орны цагаан хэрэглэл, бүтээлэг, хулдаас авч сүрьеэгийн тасгийг иж бүрэн тохижуулсан. ЭМСайдын 382, 423 тоот тушаалаар пульсоксимер 6ш, ууршуулагч 2ш, зүрхний бичлэгийн аппарат 2ш, тариурын автомат шахуургын төхөөрөмж 1ш, ларингоскоп 1ш, амбу 1ш, утлагын аппарат 1ш, амьсгалын аппарат 1ш, О2 өтгөрүүлэгч 3ш, сорох төхөөрөмж 1ш зэрэг 30.0 гаруй сая төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмжөөр хангагдаж ЭМСалбарт нийтдээ 1.2 тэр бум төгрөгийн тоног төхөөрөмж олгогдсон. | 0.3 |
| 2009-2011 онуудад шаардлагатай машины судалгааг ЭМЯ-нд хүргүүлж ЭМЯ-ны сайдын баг аймагт ирэхэд асуудлыг танилцуулж явуулын тоноглогдсон автомашиныг нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлгүүдэд үе шаттай олгоно гэсэн хариуг өгсөн. 2009 онд Нэгдсэн эмнэлэгт тоноглогдсон автомашин олгогдоод байна. | 0.3 |
| “Эхийн эндэгдлийг бууруулах” төслийг үргэлжлүүлэх зорилгоор 2009 оны эхний улирлын үзлэгийг сумдын эмнэлэгийн санхүүжилтээр нарийн мэргэжлийн эмч нарын баг бүх сумдад ажиллаж нийт 2600 иргэдийг хамруулан үзлэгээр илэрсэн өвчлөлийн байдлыг бүртгэн эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авснаас 510 жирэмсэнийг үзлэг шинжилгээнд хамруулан, эрхтэн тогтолцооны эмгэгтэй жирэмсэнг эмчлэн, эрсдэлтэй жирэмснийг дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлэх арга хэмжээ авч ажилласан. Баянмөнх, Дархан, Батширээт, Галшар, Баян-Адарга суманд нарийн мэргэжлийн сүрьеэ, хүүхдийн эмч нарын баг ажиллуулж 435 хүнд үзлэг хийсэн. Батноров сумын УБ хот дахь нутгийн зөвлөлийн санаачлагаар Солонгос эмч нар Батноров суманд үзлэг хийсэн. | 0.3 |
| "Багийн хөгжлийг дэмжих" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд багийн дэлгэрэнгүй судалгааг шинэчлэн гаргалаа. 2009 оны төгсөлтөөс 4 багт шинээр эмч хуваарилав. Тогтвортой амьжиргаа-2 төслийн шугамаар 6 суманд мотоцикл, 2 багийн эмчид морь олгосон. Мөн 7.2 сая төгрөгийн өртөгтэйгөөр Өмнөдэлгэр, Батширээт, Норовлин, Дадал, Мөрөн сумын багийн эмчийн байрыг тохижуулсан. ХЯБХ-ийн санхүүжилтээр Дадал суманд 1 мотоцикл олгосноор хөдөөгийн алслагдсан багийн малчдад хүргэх эмнэлгийн тусламжийг цаг алдалгүй хүргэх боломжоор хангагдлаа. | 0.3 |

| | |
|---|---|
| ЭМСайд, БОСайдын хамтарсан 51/75 тоот тушаалын дагуу Хэрлэн сумын нутаг дэвсгэр байгаа 13 худгийн эрүүл ахуй, усны чанар аюулгүй байдалд үнэлгээ хийхэд бохирдуулагч эх үүсвэрээс 9 худаг 500 м-т, 1 худаг 250 м-т, 2 худаг 50-100 м-т байгаа бөгөөд тус бүр 50 м хамгаалалтын бүс тогтоосон байна. Ундны ус нь стандартын шаардлага хангаж буйг үнэлэхэд 83.3 %-тай байна. Нийт худгийн ажилчдад усан хангамжийн эрүүл ахуйн талаар мэдээлэл зөвлөмж өгч ажилласан. Мөн үерийн улмаас 1.2 багийн айл өрхүүдийн бохирын цооног хальж хөрсний бохирдол үүссэн тул айл өрхөөр явж судалгаа гарган 2 багийн 230 өрхийн хашаа, гудамж, дэлгүүр хоршоо, худаг, албан байгууллага орчмын 904500 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн. Хэрлэн сумын 400 айл өрхөд авгалдай устгал, гэдэсний халдварын 151 голомтонд халдвар судалгаа голомтын халдваргүйтгэл хийсэн. Халдварт шар өвчин /211/ өнгөрсөн оны мөн үеэс 194 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. 2009 оны байдлаар нийт 960 халдварт өвчин бүртгэгдсэн нь 2008 оны мөн үеэс 468 тохиолдлоор буюу 32.77 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | 30 |
| Халдварт өвчин 10000 хүн амд 141.4 промил байгаа нь улсын дундажын түвшинд, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 32.77 хувиар буурсан. Халдварт шар өвчний өвчлөл ихсэх хандлагатай байгаа Бор-Өндөр, Батширээт сумын эмнэлгийн эрхлэгчид зөвлөмж өгч мэдээлэл солилцон ажилласан. Нийт халдвараар Баянмөнх, Хэрлэн сумдад өвчлөл 10000 хүн амд 163.2-386.0 промил байна. БГХӨСТөвтэй хамтран Хэрлэн сум болон Бэрх тосгонд нохой галзуурсан тул БГХӨСТөв хавьтагсдыг халдвар судлалын шаардлагаар галзуугийн эсрэг вакцинд хамруулан "Галзуу өвчнөөс сэргийлэх" ажлыг эрчимжүүлэх тухай аймгийн Засаг даргын 02 тоот албан даалгаварыг бүх сумдад хүргүүлсэн.<br>Томуу томуу төст өвчний гаралт нэмэгдэж шинэ вирусийн халдвар гарсантай холбогдуулан Томуугийн А /H1N1/ шинэ вирусийн халдвараас хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан, ДЭМБ, ЭМЯамны зөвлөмж, Засаг даргын 263, 267, 270 дугаар захирамжийн дагуу холбогдох арга хэмжээ авч ажилласан. | |
| ЭМБ-ын эмч мэргэжилтнүүд томуугийн А хүрээний H1N1 вирусын халдварын талаар хүүхдийн байгуулагуудад хамар залигуурын үзлэг хийж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгааг тогтмол хийсэн. Мөн хамгаалах өмсгөл, халдваргүйтгэлийн бодис, вирусын эсрэг эмийг эмнэлгүүдэд хувиарлан хүргүүлж, нөөц бүрдүүлэн ажиллаж байна. Хэнтий аймагт H1N1-н лабораториор батлагдсан тохиолдол 11, эмнэл зүйгээр сэжигтэй 66 тохиолдолыг тусгаарлан эмчилсэн. | 30 |
| Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр бүх сумдын ЗДТГазартай хамтран айл өрх, албан байгууллагуудыг стандартын шаардлага хангасан бие засах газар, бохирын цооногтой болгох болзол, уралдаан зарлаж, арга зүйн зөвлөмж өгч ажилласан. Хэрлэн, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Дадал, Биндэр, Баян-Адарга, Галшар сумд санаачлагатай ажиллаж 158 өрх, 50 байгууллага стандартын бие засах газар шинээр барьсан байна. | 30 |

| | |
|---|---|
| ХДХВ/ДОХ/БЗДХалдварын харуулдан тандалтын судалгаанд 203 жирэмсэн эмэгтэй, 102 хөдөлгөөнт хүн амыг хамруулсан. Хөтөлбөрийн зохицуулагч 0419-р ангид хүмүүжигч болон цагдаагийн газарт байцаагдаж байгаа залуучууд, ЕБС-ийн ахлах ангийн сурагчид нийт 600 хүнд халдвараас сэргийлэх, бэлгийн зөв дадал олгох сургалт, нийт 2378 хүнд сургалт сурталчилгаа хийж 65 хүнд утсаар зөвлөгөө өгч ажилласан."100% бэлгэвчийн хэрэглээ" хөтөлбөрийн чиглэлээр нийтийн цэнгээний газар, зочид буудал зэрэг 26 байгууллагаар явж зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулав. Кабинетийн эмч төв хөдөөд нийт үзлэг 5238, урьдчилан сэргийлэх үзлэг 4870, цэргийн насны 1665 залуучуудыг үзлэг шинжилгээнд хамруулсан ба идэвхтэй үзлэг 427, серологи 3955, мазак 3207, ХДХВ 3648 үзлэг шинжилгээ хийж 383 өвчлөл илрүүлэн эмчиллээ. | |
| ***Сүрьеэгийн талаар:*** Орон нутгийн өндөр эрсдэлтэй хүн амын дунд сүрьеэгийн идэвхтэй үзлэг зохион байгуулж 120 хүнийг шинжилгээнд хамруулж нийт 14 сүрьеэ илрүүлж 78 хавьтлыг 14 хоногт багтаан үзлэг шинжилгээнд оруулсан. Бор-Өндөр, Баянмөнх суманд ажиллаж сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт 45 хүн, хяналтын 17 хүн, хавьтлууд 68 хүн нийт 130 хүнийг үзэж зөвлөгөө өгч, цэрний шинжилгээ хийсэн.Цэргийн үзлэгээр 652 хүн үзлэгт орсноос сүрьеэгээр 9 хүн цэргийн албанаас хасагдсан. Биндэр, Батноров, Баян-Овоо, Баянмөнх, Бор-Өндөр сумын эмнэлгүүдэд *"Лаборантын үйл ажиллагааг сайжруулах дэд төсөл"* хэрэгжиж 126 хүний цэрний шинжилгээ авч идэвхтэй хэлбэрийн сүрьеэ 4-ийг илрүүлсэн. Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгээс сүрьеэтэй 12 иргэнийг 6 сарын турш хооллож, хяналттайгаар эмийг харж уулгаж байна. Дэлхийн зөн ОУБ-аас зарласан "Шилдэг аймаг шалгаруулах уралдаан"-д шалгарч 5.0 сая төгрөгийн төсөл хийх эрхийн бичгээр шагнуулж 7500.0 төгрөгийн төсөл хийж сүрьеэгийн тасгийг иж бүрэн тохижуулсан. | |
| Сүрьеэгийн халдвараас сэргийлье" ажлын хүрээнд "Бид чадна", "Гар зургийн уралдаан", *Шилдэг өрх, сумын эмнэлэг* шалгаруулах уралдааны удирдамжийг дүгнэж ажилласан. Аймгийн Засаг даргын 115 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулж, 27 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлдөх уулзалт зохион байгуулж шийдвэр гаргагч нарын түвшинд асуудлаа тодорхойлж зөвлөмж гаргалаа. Сүрьеэгийн 28 голомтонд халдвар судалгаа хийж нийт 15 байгууллага, 1000 гаруй иргэдэд сурталчилгаа хийж, гарын авлага материал тараасан. Эдгээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд 2008 оны мөн үеэс БЗДХалдвар 9 тохиолдлоор, сүрьеэ 45 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна. | 0.3 |
| Өмнөдэлгэр сумын хүн амын усан хангамжийг сайжруулах зорилгоор Дэлхийн зөн ОУБ-ын санхүүжилтээр 17.0 сая төгрөгийн өртөгтэй 1 худаг, ТАТ-2 төслийн санхүүжилтээр 12.2 сая төгрөгийн өртөгтэйгөөр 1 худаг гаргаж усны дээжийг Усны эрдэм шинжилгээний хүрээлэнд шинжлүүлэн, шүүлтүүр тавиулах асуудлыг шийдвэрлүүлэх шатанд явж байна. ДЭМБ-ын хөрөнгө оруулалтаар Цэнхэрмандал сумын эмнэлэгийг цэвэр бохир усны холболтыг хийж эрүүл ахуйн шаардлага хангасан гүний худагтай болголоо. | 0.3 |

| | |
|---|---|
| Аймгийн хэмжээнд нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх бүх нийтийг хамарсан төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулж иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр сумдад 2/604 тоот албан бичиг хүргүүлж биеийн тамир, спортын нийтийг хамарсан явган аялал, бүх нийтийн алхалт, гүйлт, нэрэмжит тэмцээн уралдааныг тогтмолжуулснаар иргэд хамт олны оролцоо сайжирч байна. АЗДТГ, Хэрлэн сумын ЗДТГ, ДЗОУБ, ЭМГ, БТСГазар хамтран зохион байгуулсан МУЗГ-ын 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийтийг хамарсан 12 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор Хэрлэн сумын 145 байгууллагын 3423 иргэн хамрагдлаа. Өмнөдэлгэр , Норовлин, Жаргалтхаан, Баян-Адарга, Баянмөнх, Баянхутаг, Баян-Овоо, дадал, Мөрөн сумдууд давхардсан тоогоор спортын 13 төрлөөр 63 удаагийн тэмцээн зохион байгуулж 5600 гаруй иргэд хамрагдсан байна. | 0.3 |
| БТСГазарт орчин үеийн спорт тоглоом, сургалтын техник хэрэгсэл шаардлагатай талаар УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Д.Арвин нарт танилцуулж, албан бичгээр санал хүргүүлж, ДЗОУБ-д 32.5 сая төгрөгийн төсөл бичиж санал тавиад байна. Одоогоор 5.5 сая төгрөгийн өртөгтэй аппаратур, техник хэрэгсэлээр хангагдлаа. Үүнд: 1сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 0.1 |
| Волейбол, шатар, ширээний теннис, жүдо бөхийн төрлөөр өсвөрийн шигшээ багийн тамирчдын сургалт дасгалжуулалтыг тогтмолжуулах, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд өсвөр үеийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд Шатарын төрөлд 18 тамирчин оролцож Бэрх тосгоны Б.Оюунболор, Батсувд мөнгөн медаль, Э.Нямбилэг хүрэл медаль, Ширээний теннисний төрөлд 7 тамирчин оролцож 1 бүрчилсэн төрөлд 5,7-р байр багийн дүнгээр 6-р байр, Волейболын төрөлд 22 тамирчин 2 дасгалжуулагч оролцож охидын баг шигшээ 8 багт шалгарч УАШТэмцээнд өрсөлдөж 6-р байрт, Жүдо бөхийн төрөлд 19 тамирчин, 5 дасгалжуулагч оролцож 1-алтан медаль, 2-мөнгөн медаль, 4- хүрэл медаль, цанын төрөлд 6 тамирчин оролцож Биндэр сумын тамирчин Ч.Азбаяр 10 км-т алт, 5 км-т хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ. Дэлхийн аварга шалгаруулах Жүдо бөхийн тэмцээнд оролцсон Оюунсувдад 1500.0 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Аймгийн Засаг даргын захирамжаар спортын арга хэмжээнд 9843,4 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 0.3 |

| | |
|---|---|
| Өсвөр үеийн Үндэснйи бөхийн УАШТэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах комисс, шаардагдах хөрөнгийг Аймгийн Засаг даргын захирамжаар баталж, 2009 оны 1 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд Өндөрхаан хотод амжилттай зохион байгуулагдсан. Тэмцээнд 20 аймаг, 47 байгууллагын 165 тамирчин 2 насны ангилалд өрсөлдсөнөөс Увс аймгийн баг тамирчид багаараа тэргүүлж, бага насны ангилалд Хэнтий аймгийн Батноров сумын харъяат тамирчин Э.Дарханбат түрүүлж алтан медаль хүртлээ. Урианхай сурын тэмцээнд 1 алт, багаараа хүрэл, дэд мастерын болзол 1 тамирчин хангаж, 2010 онд Хэнтий аймагт зохиогдох Жү-до бөхийн залуучуудын УАШТэмцээнийг зохион байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна. | 0.5 |
| Үндэсний спортыг хөгжүүлэх, тухайн төрлөөр орон нутгаас төрөн гарсан алдартнуудын залгамж халааг бэлтгэх, үндэсний бөхийн төрлөөр хичээллэх өсвөрийн тамирчдын оролцоог нэмэгдүүлэн, ур чадварыг нь дээшлүүлэх зорилгоор “Хэнтий-Аварга” бөхийн дэвжээ үйл ажиллагаагаа явуулж байна. Секцэнд 8-14 насны 90 өсвөрийн тамирчин, сурагч хамрагдаж 7 хоногийн 4 өдөрт 8 удаа 16 цагаар 2 ээлжээр хичээллэж, бямба гараг бүрт секцэнд хамрагдаж буй хүүхдүүдэд ур чадвар суулгах, бөхийн ёс жаягийг хэвшүүлэх зорилгоор хүүхдийн барилдааныг бөхчилсөн хэлбэрээр тогтмол зохион байгуулж байна.<br>Сард нэг удаа сургалт дасгалжуулалтын үр дүн, чанарыг тодорхойлох “Сорилго барилдаан”-ыг 3 насны ангилалаар, бай шагналтай, ивээн тэтгэгч байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулж байна. | 0.5 |
| МУ-ын ЗГ-ын 2009 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 211 дүгээр тогттоолын дагуу 2010 онд Үндэсний спортын IY наадмыг орон нутагт зохион байгуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна. | 0.1 |

| | |
|---|---|
| Биеийн тамир, спортын салбарын боловсон хүчний ур чадварыг дээшлүүлэх, туршлага солилцуулах зорилгоор Улаанбаатар хотод МҮОХороо, ОУОХороо хамтран зохион байгуулсан Жүдо бөхийн дасгалжуулагчдын Олон улсын 10 хоногийн сургалт семинарт БТСГазрын жүдо бөхийн дасгалжуулагч Н.Ганзориг, Чийрэгжүүлэлт, бялдаржуулахын багшлах, дасгалжуулах эрх олгох 8 кредит бүхий 10 хоногийн сургалт семинарт "Хүчтэн" фитнес клубын дасгалжуулагч Д.Эрдэнэбилэг нар оролцлоо. "Нутгийн салхи" хөтөлбөрийн хүрээнд УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Нямдорж, Данзан нар ирж 10 сарын 8-9-ний өдрүүдэд Биеийн тамирын багш, арга зүйч нарын сургалтыг зохион байгуулахад 42 багш, арга зүйчид хамрагдлаа. Энэ үеэр Жүдо бөхийн багш, дасгалжуулагчдын сургалт, чөлөөт тоглолт, тэмцээн уралдаан явагдлаа. Сүхбаатар аймагт зохиогдсон Зүүн бүсийн 5 аймгийн "Идэвхтэй хөдөлгөөн-Зөв хооллолтыг дэмжих хамтын ажиллагааг сайжруулъя" сэдэвт сургалтанд ЭМГ, БТСГазраас 7 мэргэжилтэн хамрагдлаа. Монголын чөлөөт бөхийн холбооноос зохион явуулсан "Чөлөөт бөхийн сургалт дасгалжуулалтын технологийн шинэчлэлт" сэдэвт сургалтанд БТСГ-ын ахлах мэргэжилтэн П.Ганболд, Хэрлэн 1-р сургууль, ТЦ сургууль, Норовлин, Өмнөдэлгэр сумын багш нар оролцлоо. | 0.3 |
| | 0.297 |

ЖҮҮЛЭХ, ГАДААД ХАРИЛЦААГ ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ

тэй, санаачлагатай, цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлнэ.

| | |
|---|---|
| Бүх сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, тайланд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн байр эзлүүлж, цаашид анхаарах зүйлсийн талаар зөвлөмж хүргүүлээд байна. 11 дүгээр сарын 16-21-ний хооронд Мөрөн, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр сумд, Хэрлэнбаян-Улаан тосгоны Засаг даргын мөрийн хөтөлбөр, сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд илтгэх хуудсаар танилцуулсан. | 30 |
| Аймгийн Засаг дарга аймгийнхаа бүх сумдаар явж ажил байдалтай нь танилцан өөрийн хийсэн ажлын тайланг сумдын иргэдэд тавин тухайн сумын Засаг дарга нар өөрсдийн 2009 онд хийсэн ажлын тайлангаа мөн адил танилцуулла.Үүнд нийт 2000 гаруй иргэд хамрагдлаа. 2009 онд Засаг даргын зөвлөлийн хурлыг 18 удаа зохион байгуулж үүнд орон нутгийн мэдээллийн хэрэгсэл болох САНБҮРД ОСТ, FM106.2 радиогоор дамжуулан аймгийнхаа иргэдэд хүргэж байна. Агентлагын дарга нартай 3 удаа, Сумдын засаг дарга нартай 3 удаа, аймгийн хэмжээний бүх багийн Засаг дарга /83/ нартай 1 удаа уулзалт зохион байгуулж, хийж гүйцэтгэсэн ажил, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлаа танилцуулж, энэ тухайгаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэддээ хүргээд байна. | 0.3 |

| | |
|---|---|
| Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдлын мөрөөр аймгийн Засаг дарга ажлын хэсэг томилон сумдад ажиллуулж, дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн тухай бүрт хариуцлага тооцон ажиллаж байна. Засаг даргын зөвлөлийн хурлаас Дэлгэрхаан сум, Хэрлэнбаян-Улаан тосгоны сургуулийн захирлууд, 9 сумын Засаг дарга, МХГ-ын дарга, Бэрх тосгон ы захирагчийн орлогч зэрэг албан тушаалтнуудад сануулах, 1-3 сар цалин бууруулах арга хэмжээ авсан. 2009 оны жилийн эцсийн тайлангаар Хэнтий аймгийн төрийн захиргааны байгууллагуудад иргэдээс 5363 өргөдөл гомдол ирсний 1043-ыг амаар, 4320-ийг бичгээр ирүүлжээ. Үүнээс 4968 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч, 336 өргөдлийг холбогдох байгууллагад шийдвэрлүүлэхээр шилжүүлэн, 59 өргөдлийг шийдвэрлэх хугацаа болоогүй хүлээгдэж байгаа дүнтэй гарсан байна. | 30 |
| Аймгийн МХГ, ХХҮХ-ийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, ЭМГ, ХХААЖДҮГ,-ын ажлын төлөвлөгөөний явц байдлын талаар Засаг даргын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар тус тус хэлэлцүүлж, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгүүллээ. Мөн энэ хугацаанд 5 сумын ЗДТГ, БГХӨТГ-ын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийж, зөвлөмж өгсөн. | 30 |
| Цэц монгол, Дөлгөөн хэрлэн төв, скаутын зөвлөл, ИНБ-ын сүлжээ төрийн бус байгууллагуудыг дэмжин туслах чиглэлээр аймгийн ЗДТГ, ИНБ-уудын сүлжээний 2009 онд хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан 1065000 төгрөгийн зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлээд байна.Иргэдээс санал, хүсэлт авах нээлттэй утасыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн 23303 утасаар хүлээн авч байгаа ба одоогоор авлигатай холбоотой мэдээлэл ирээгүй болно.<br>Цагдаагийн газрын ажлын хэсэгтэй хамтран 2009 оны 4 дүгээр сарын 16-наас 2009 оны 4 дүгээр сарын 21-ний өдрүүдэд Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр сум, Хурх тосгонд ажиллаж ,авлигын мөн чанар, хор хөнөөлийн талаар сумдын Тамгын газрын ажилтан, албан хаагч, аж ахуйн нэгж, байгууллагын дарга / 96 / нарт сургалт, иргэд хөдөлмөрчдөд / 338 / яриа таниулга хийж, 2 төрлийн санамж, сэрэмжлүүлгийг / 500 ширхэг / тараав.<br>2009 оны 5 сард НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Авлигатай тэмцэх газраас хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсад шударга, ил тод байдлыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх “ төслөөс шударга ёс, ил тод байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх санал тавьсаны дагуу ажлын хэсэг томилон "Шудрага ёс ил тод байдлын үйл ажиллагааны" нийт 4 тулгуур, 6 зорилт, 28 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2009 оны 07 сарын 2-ны өдрийн 68 дугаар тогтоолоор батлуулан ажиллаж байна.Төлөвлөгөө боловсруулах явцад 17 сум, 2 хот, 2 тосгоны нийт 1475 иргэдээс санал асуулга, судалгаа авч иргэд, төрийн байгууллагын ажилтнуудтай уулзаж хийсэн ба аймгийн ИТХ-ын төлөөлөгчид,ИНБ-ын сүлжээ, иргэний зөвлөлийн гишүүд оролцсон 3 талт хэлэлцүүлгийг зохион байгуулж төлөвлөгөөний төсөлд олон нийтийн санал авсан.Нээлттэй утас ажиллуулж, /23902 23303 99566681 93014555 / төлөвлөгөө боловсруулах явцад 1969 утсанд 1 иргэн, бусад утсанд 16 иргэн хандсан. | 0.5 |

| | |
|---|---|
| Аймгийн ЗДТГ-т иргэдээс санал гомдол хүлээн авах 23303 дугаарын утас, Хэрлэн суманд 23804 дугаарын утсыг тус тус тогтмол ажиллуулж 2009 онд 29 иргэнээс нийт 32 санал, хүсэлт хүлээн авч барагдуулж ажиллав. Иргэдийн саналын мөрөөр асуудал тавьж, ЕБ-ын сургуулиуд сурагчдаас мөнгө авах явдлыг таслан зогсоож, хот хооронд зорчдог шуудангийн автобусны тасалбарын үнийг үйлчилгээ эрхлэгч байгууллагатай зөвшилцөн 2500 төгрөгөөр бууруулав. Өндөрхаан хотын тохижилт соёлжилтын талаар иргэдээс ирүүлсэн саналын дагуу хот тохижилтын 3 сарын аян зохион байгуулж, энэ ажилд 30 гаруй сая төгрөг зарцуулллаа. Иргэдийн саналын дагуу үерийн далан байгуулж, үер усны аюулаас ард иргэдийг хамгаалах ажлыг зохион байгуулж үр дүнд хүрч байна. | 30 |
| Аймгийн Засаг даргын эрх хэмжээний хүрээнд 2009 оны 11-р сарын 23-ныг хүртэл хугацаанд 329 захирамж, Тамгын газрын даргын 110 тушаал гарсан байна.Сумдын Засаг даргын 893 захирамж, Тамгын газрын даргын 155 тушаал хянаж, Засаг даргын 186 зөрчилтэй захирамж, Тамгын газрын даргын 22 зөрчилтэй тушаалын зөрчлийг өөрсдөөр нь арилгуулах арга хэмжээ авч, хууль зүйн зөвлөгөө өглөө. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар зөрчил гаргаагүй аж ахуйн нэгжийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад зөвхөн тухайн орон нутгийн Засаг даргын саналыг үндэслэн сунгаж байхаар шийдвэрлэсэн ба 2009 оны 6 сарын 1-ээс хэрэгжүүлэн ажиллаж байна. | 0.3 |
| Аймагт хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслийн зохицуулагч нартай мэдээлэл солилцох, уулзалтыг 2009 оны 2 сард зохион байгууллаа. Аймагт хэрэгжих төсөл, хөтөлбөр, тендер шалгаруулалтыг ил тод нээлттэй байлгаж, хяналт тавих үйл ажиллагаанд нь иргэний нийгмийн байгууллагуудаас оролцуулж ажиллаж байна.Хэнтий аймагт хэрэгжиж буй олон улсын томоохон төслүүд болох Хөдөөгийн ядуурлыг бууруулах төсөл, Малын индексжүүлсэн даатгал, Эрүүл мэндийн салбарын хөгжил-2, Тогтвортой амьжиргаа-2 төслийн байгууллагууд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй нягт уялдаа холбоотой ажиллаж иргэдэд үйл ажиллагааны мэдээ мэдээллээ тогтмол өгч хэвшсэн. Аймгийн Засаг даргын зөвлөлийн бүрэлдэхүүнд иргэний нийгмийн байгууллын төлөөлөл- ТББ-ын хобооны тэргүүн багтаж ажиллах болсон бөгөөд тендер сонгон шалгаруулах хорооны бүрэлдэхүүнд мөн иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оруулах бодлого барьж ажиллаж байна. | 70 |

| | |
|---|---|
| Аймгийн Эрүүл мэндийн газар, ХХААЖДҮГ, МХГазар, БГХӨТГазар, ХХҮХэлтэсийн хагас жилийн тайланг Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар өргөтгөсөн байдлаар авч хэлэлцлээ. Үүнд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг байлцуулан тайлангийн талаархи мэдээллүүдийг аймгийн ЗДТГ-аас эрхлэн гаргаж буй "Мэдээлэл" сэтгүүл, орон нутгийн "Санбүрд" ОСТВ, FM2-ийн радио сувгуудаар иргэд, хөдөлмөрчдөд танилцууллаа. Монгол улсын тусгаар тогтнолын тухай бүх нийтийн санал асуулга явуулсан 10 сарын 20-ны өдрийг "Нээлттэй халганы өдөр" болгон жил бүр орон даяар зохион байгуулж байгаатай холбогдуулан хийсэн ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 120 газарт болсон уулзалт хуралд 16452 иргэд оролцон, 573 хүн үг хэлж, 718 санал хүсэлт дэвшүүлсэн байна. Сум, байгууллагууд телевизийн шууд ярилцлагаар иргэдээс 33, саналын хайрцгаар 802, нээлттэй утсаар 102 санал хүсэлт, гомдол хүлээн авч, өөрсдийн үйл ажиллагааны талаар 1903 иргэнээс санал асуулга авч, дүгнэж ажилласан байна. | 0.3 |
| Дархан, Батноров сумдын ИТХ-ын санал, санаачлагыг үндэслэн асуудлыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газарт уламжилжлаад байна | 30 |
| 2009 онд Дархан, Дадал сумдад тус бүр нэг багийн төвийг шинээр нээж, багийн Засаг даргыг нь мотоциклоор хангалаа. **Баян-Адрага** сумын Жаргалант баг /2/, **Батноров** сумын Эрдэнэчандмань баг /1/, **Баянмөнх** сумын Хэрлэн баг /2/, **Дархан** сумын Хараат /2/ бат, **Мөрөн** сумын Зөөлөн /1/ баг, **Өмнөдэлгэр** сумын Баянзүрх /2/ баг **Биндэр** сумын Баянгол /3/ багийг жишиг баг болгон ард иргэдийн болон төсөл хөтөлбөрийн тусламжтайгаар бүрэн тохижуулан үйл ажиллагаа явуулж байна. **Баян-Овоо, Жаргалтхаан, Хэрлэн, Норовлин, Дэлгэрхаан, Цэнхэрмандал Галшар** сумдууд жишиг баг байхгүй. **Дадал** сум Онон /1/ баг, **Батширээт** сумын Хурх /3/ баг, **Баянхутаг** сумын Цантын хоолой /3/ багийг жишиг баг болгохоор ажиллаж байна. Нийт 7 сум жишиг багийн төвтэй, 3 сум багийн төвөө жишиг баг болгохоор зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд 7 сум жишиг багийн төвгүй байна. | 30 |
| ТА-II төслөөс 2009 онд Батширээт сумын багийн эмнэлгийн дээвэр 388,0 төгрөг, эмчийн унаа морь, мотоцикл 1,7 сая төгрөг, Биндэр сумын багийн эмчийн унаа мотоцикль 2,6 сая төгрөг, эмнэлгийн засвар 1,3 сая төгрөг, Дэлгэрхаан сумын 4 дүгээр баг, Баянхутаг, Цэнхэрмандал сумын багийн эмчийн мотоцикль-3,9 сая төгрөг, Өмнөдэлгэр сумын багийн төвийн тохижилт 540,0 төгрөг, Норовлин сумын багийн эмнэлэгийн тохижилт-646,0 төгрөг, Мөрөн сумын багийн эмчийн өрөөний тохижилт-417,0 мянган төгрөг, багийн эмнэлэг засвар-1,1 сая төгрөг, Баянмөнх сумын багийн төвийн тохижилтонд 576.0 мянган төгрөг, ХЯБХөтөлбөрөөс 1.2 сая төгрөгийн техник хэрэгсэл, сургалтын тоног төхөөрөмж тус тус олгосон. Нийт 9 сумын 12 багт 14367,0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдээд байна. Аймгийн төвийн 4 багийг жижиг оврын трактороор хангаж хог хаягдал тээвэрлэхэд ашиглаж байна. | 30 |

| | |
|---|---|
| Багийн үйл ажиллагаанд зориулан Багийн Засаг даргын цалин, бичиг хэрэг, шуудан холбоо, тээвэр шатахуун, албан томилолт, урсгал зардал гэсэн зардлуудыг сумдын жил бүрийн төсөвт тусган олгож байна. | 30 |
| Аймгийн 83 багийн 9 багийн Засаг дарга унаагаар хангагдсан. Үүнд мотоцикль-5, машин-4 /тосгоны захирагч нарын/ байна. Бусад багийн дарга нар хувийн мотоцикль болон, мориор албан ажлаа явуулж байна. Дархан сумын Хараат багийн Засаг даргыг аймгийн Засаг даргын нөөц сангаас мотоциклоор хангасан. | 30 |
| 2009 оны сургалтын төлөвлөгөөний дагуу багийн Засаг дарга нарын сургалтыг Өндөрхаан хотноо 12 дугаар сарын 3,4-ний өдрүүдэд зохион байгууллаа. Дархан сумын 5 дугаар багийн Засаг дарга Дорнод аймагт ЗГХЭГ-аас зохион байгуулсан сургалтанд хамрагдаад байна.Баянмөнх сумын багийн Засаг дарга нар бэлчээрийн менежмент, хортон мэргэчидтэй тэмцэх арга болон хууль эрх зүйн сургалтанд орон нутагтаа 2 удаа хамрагдаж гарын авлагаар хангагдаад байна. | 50 |
| 2010 оноос | |
| 2011 оноос | |
| Судлах шатандаа явж байгаа бөгөөд 2010 оны төсөвт тусгасан<br>-Батширээт-3ш<br>-Биндэр-2ш<br>-Өмнөдэлгэр-2ш<br>-Цэнхэрмандал-0 Жаргалтхаан-2ш үлээгч, РЛО- 5ш | 10 |
| Судлах шатандаа явж байгаа бөгөөд 2010 оны төсөвт тусгасан Дадал суманд -3ш<br>Норовлин-5ш<br>Баян-Адарга-4ш<br>Жаргалтхаан-2ш үлээгч, РЛО- 5ш | 2010 оноос |
| Биндэр, Өмнөдэлгэр, Батширээт, Галшар, Дэлгэрхаан, Баянмөнх сумдад гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, Дадал, Норовлин, Жаргалтхаан, Галшар сумдад гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг тус тус зохион байгуулахдаа сумын Онцгой комисс, Онцгой байдлын орон тооны бус штаб, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиудыг хүн нэг бүрийн аранзаар жигдрүүллээ. Үүнээс Норовлин, Жаргалтхаан, Хэрлэн сумдын ОК, мэргэжлийн ангиуд хувцсаар жигдэрсэн. | 30 |

| | |
|---|---|
| 2009 онд ОБГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө болон сургалтын хөтөлбөрт заасны дагуу аймгийн Засаг даргын 2009 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 72 дугаар захирамжаар Биндэр, Өмнөдэлгэр, Батширээт сумдад гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулж аймаг, сумдын онцгой комисс, штаб, мэргэжлийн анги, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх анхан шатны мэдлэг олгох чиглэлээр дараах сургалтуудыг явууллаа. Үүнд:<br>-Удирдах ажилтны сургалт болон команд штаб, Иж бүрэн сургуулийг Дадал, Норовлин, Жаргалтхаан сумдад буюу 3 удаа,<br>-Аймгийн Онцгой комиссын гишүүдэд 1 удаа<br>-Ажилтны сургалтыг 26 удаа,<br>-Мэргэжлийн анги, аймгийн гамшгаас хамгаалах албадын сургалтыг Хэрлэн, Биндэр, Дадал, Норовлин, Жаргалтхаан сум, Өлзийт, Тахилгат тосгонд нийт 7 удаа,<br>-Сурагчдын сургалтыг 1,2,3,4–р дунд сургууль, 1,2,3,4,5-р цэцэрлэг, Дадал, Норовлин, Жаргалтхаан сумдын сургуулиудад нийт 12 удаа,<br><br>Иргэдийн сургалтыг Хэрлэн, Дадал, Норовлин, Жаргалтхаан, Биндэр, Норовлин, Жаргалтхаан суманд нийт 7 удаа нийт 54 удаагийн 256 цагийн сургалтыг тус тус явуулж албан тушаалтан болон иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхөд гал түймэр, гамшиг ослын аюулаас урьдчилан сэргийлэх санамж анхааруулга тараав. | 30 |
| Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг Дадал, Норовлин, Жаргалтхаан сумдад 4 сард, Галшар суманд 10 сард тус тус зохион байгуулж явуулсан. Дээрх сургалтанд сумын ОК, орон тооны бус штаб, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, аж ахуйн нэгж байгууллагын удирдлагыг хамруулж онол, дадлагын хэлбэрээр 3 өдөр зохион байгуулж явуулсан. Жаргалтхаан, Норовлин, дадал сумд дүүрэн хангалттай, Галшар сум хангалттай үнэлгээ авсан. | 30 |
| 2009 оны эхний хагас жил газрын үйл ажиллагааны төлөвлөгөө болон сургалтын хөтөлбөрт заасны дагуу аймгийн Засаг даргын 2009 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 72 дугаар захирамжаар Биндэр, Өмнөдэлгэр, Батширээт сумдад 4-р сард, Баянмөнх, Дэлгэрхаан, Галшар сумдад 10-р сард Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулж сумдын онцгой комисс, штаб, мэргэжлийн анги, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд гал түймэр, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх анхан шатны мэдлэг олгож гамшиг осолтой тэмцэх хүн хүч, машин техник, багаж зэвсэглэмжийн бэлэн байдлыг хангуулсан. | 30 |
| Энэ онд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гамшигтай тэмцэх санд 2009 оны төсөвт 86.0 сая, тодотголоор 9.0 сая, нийт 95.0 сая төгрөгийг төвлөрүүлж, гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээнд зарцуулж байна. Үүнд: 2009 оны 7-р сард болсон үерт 2,8 сая, 5, 6 сард болсон цасан шуурганд 3,4 сая, Гал унтраах 49-р ангийн байрны засварт 8,9 сая, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх шуурхай бүлэг ажиллуулахад 4,8 сая, сумдын дунд болзолт уралдааны зардалд 1.0 сая, бэлэн байдлын үзлэгийн зардалд 218,4 мян.төг, цурав тавихад 5,7 сая, суудлын автомашинд 5.0 сая нийт 31.869.0 сая төгрөг зарцуулсан байна. | 30 |

| | |
|---|---|
| Байгалийн аюулаас урьдчилан сэргийлэх хохирол нөхөх санг бүрдүүлэх талаар анхаарч Дэлхийн Зөн ОУБ, Дэлхийн байгаль хамгаалах сан зэрэг гадаадын төслийн байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлж байна. ТА-2 төслөөр 2008 оны 5 сард болсон байгалын гамшгийн улмаас малгүй буюу цөөн малтай болсон айл, өрхүүдийг малжуулах ажилд 8 сумын 405 өрхийг хамруулан 10.0 мянган толгой охин төлөг олгосон байна. Бэрх тосгоны хөлдөлтөнд 2009 онд 18.384316 төгрөг, 2008 онд Онцгой комиссын танхим тохижуулахад 3500.000 зарцуулсан. Дэлхийн байгаль хамгаалах сангийн санхжүүлтээр 9327,0 мянган төгрөгийн төсөл хэрэгжүүлж ой, 5435 ш санамж анхааруулга, 30ш календарьчилсан төлөвлөгөө, ОБГ-ын танилцуулга ном 1500 ш, Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх гарын авлага ном 200ш, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх видео гарын авлага 333ш тус тус хэвлэж хэвлэж, ой хээрийн түймэр гарах магадлал өндөр сумдад тараалтыг хийлээ. Мөн уг төслийн хүрээнд гамшгаас хамгаалах арга хэмжээний чиглэлийн вэб сайтыг нээж үйл ажиллагааг явуулж байна. Мөн Дадал, Биндэр сумын ОХУ-тай хил залгаа нутгаар хамгаалалтын цурав байгуулахад Дэлхийн байгаль хамгаалах сангаас нийт 4.5 сая төгрөгийн санхүүжилт үзүүлсэн. | 50 |
| Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 3-р сарын 05-ны өдрийн 51 дүгээр тушаалаар тус аймагт Зүүн бүсийн Онцгой байдлын газар, хэлтсийн аврагч-гал сөнөөгч, аврагч-жолооч, дуудлага хүлээн авагч-операторын 14 хоногийн анхан шатны сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтанд 112 иргэдээс сонгон шалгаруулалт явуулж 43 иргэнийг сонгож сургалтанд хамруулсан ба сургалт амжилттай төгссөн 21 иргэнийг төрийн жинхэнэ албан хаагчаар томилж Бор-Өндөр хотын Гал унтраах 49-р ангид ажиллуулж байна. ОБЕГ-ын даргын баталсан 2009-2010 оны хичээлийн жилийн төлөвлөгөөний дагуу сургалт явагдаж байна. | 100 |
| Гал унтраах 49-р ангийн байр эзэмших талаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамж гаргуулж, аймгийн Төрийн өмчийн төлөөлөгчтэй байр эзэмших талаар гэрээ байгуулан ажиллаж байна. Бор-Өндөр хотын Гал унтраах 49-р ангийн байрыг сэргээн засварлах ажлын төлөвлөгөө, зардлын тооцоог гарган эхний ээлжинд Улын баяжуулах үйлдвэрийн захиргаатай гэрээ байгуулан 12.7 сая төгрөгийн зардлаар байрны цэвэр, бохир усны болон дулааны шугам хоолойг бүрэн шинэчилж дуусгав.<br>Мөн аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гамшигтай тэмцэх сангаас 8877,3 мянган төгрөг, тус газрын албан хаагчдын хандиваар 4800,0 мянган төгрөгийг тус тус хуримтлуулж байрны засварт шаардагдах материалыг татан авч засварын ажлыг хийж дуусгалаа. | 100 |
| Тус газрын автомашин, техникийн бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж, гамшигтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх ажилд ашиглах Фургон автомашин болон суудлын автомашин олгосон. | 70 |
| 2009 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах "Кабон" -ны хөрөнгө төсвийн тодотголоор хасагдсан. | 0 |

| | |
|---|---|
| | 2011 оноос |
| | 2010 оноос |
| | 2012 оноос |
| 2009 оны Аймгийн хөрөнгө оруулалтаар “Кабон” барилга бариулах төсөв батлагдаагүй. | 0 |
| | 2011 оноос |
| Аймаг орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2 автомашиныг 10.0 сая төгрөгөнд багтаан авч, Хэрлэн суманд хөдөлгөөнт эргүүлийн машиныг зориулалтын дагуу тоноглон ашиглалтанд оруулаад байна. | 100 |
| Аймгийн Иргэний бүртгэлийн албаны мэдээллийн системыг Монгол Улсын иргэний бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбох ажил 2009 оны 6 сард бүрэн хийгдэж дууссан бөгөөд биелэлт 100%-тай үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. | 100 |
| Сумдад иргэний бүртгэлийн лавлагаа олгодог болох асуудлын талаар эхний ээлжинд төвлөрсөн суурин газруудад нэгдсэн сүлжээ оруулахаар УБЕГ-т санал хүргүүлж 2009 оны 09 сард Хэрлэн сумын Тамгын газарт иргэний бүртгэлийн нэгдсэн сүлжээ суурилуулсан ба Бор-Өндөр, Өмнөдэлгэр, Биндэр, Батноров, Бэрх зэрэг сумдын иргэний бүртгэлийн ажилтнуудыг компьютерээр хангаж мэдээллийн баазаа зөөвөр хэлбэрээр, лавлагаа олгох бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. | 30 |
| Төрийн архивын сан хөмрөгийн данс бүртгэлийг шинэчлэх ажлыг эхлүүлээд байна.Аймгийн. ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009.07.02-ны өдрийн хурлаар стандартын нягтруулсан шүүгээ, чийгшүүлэгч аппарат авах хөрөнгийг төсвийн тодотголд оруулж хэлэлцүүлэн 5.5 сая төгрөгийг батлуулсан. Төрийн архивт 16 ширхэг нягтруулсан шүүгээ, 1 чийгшүүлэгч аппрат, Засаг даргын Тамгын газрын архивт 6 ширхэг нягтруулсан шүүгээ авч суурилуулаад байна. | 100 |
| Сан хөмрөгийн данс бүртгэлийг шинэчлэх ажлыг эхлүүлээд байна. Хувилагч машин болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжийг 2010 оны төсөвт тусгуулахаар шийдсэн болно. | 30 |
| Усны тоолуур болон хийн шингэний улсын шалгагчийг сургалтанд хамруулан бэлтгэж, усны тоолуур баталгаажуулах төхөөрөмжийн захиалгаа Стандартчилал хэмжил зүйн газарт хүргүүлж, төхөөрөмж авах хөрөнгийн асуудлаар аймгийн Засаг даргад албан ёсоор санал тавьснаар, давсан орлогоосоо 5,0 сая төгрөгийг шийдүүлж төхөөрөмжийг хүлээн авч ашиглалтанд оруулаад байна. Хүнсний мерникийг авах шаардлагагүй гэж үзсэн. | |

| | |
|---|---|
| 2009 оны 06 сарын 04-06-нд аймгийн нийт сумдын ЗДТГ-ын дарга, тосгоны Захирагчийн ажлын албаны дарга нартай батлан хамгаалах хууль тогтоомжийг ард иргэдэд хэрхэн сурталчлах, сумын цэргийн дайчилгааны бэлэн байдлын төлөвлөгөө хэрхэн боловсруулах талаар сургалтыг зохион байгуулж явуулсан<br>Сургалтанд оролцогчдыг орон нутгийн нөөц бололцоог ашиглан цэрэг татлага, сургалт, гамшиг ослын үед өмсөх хээрийн зориулалттай эрээн хувцасаар хангасан.<br>2009 оны 9 сарын 17-19-нд Зүүн бүсийн аймгуудын сумдын ЗДТГ-ын дарга нарын Цэргийн бэлтгэл сургалтыг Батлан хамгаалах яам, аймгуудын ЗДТГ-ын Цэргийн штабуудтай хамтран Дадал суманд зохион байгууллаа. | |
| Монгол улсын Засгийн газрын 2009 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан хяналтын тоонд багтаан 30 хүнийг дүйцүүлэх албанд авсан. Одоо аймгийн хэмжээнд 12 сум, 2 тосгонд 95 иргэн цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байна. Дүйцүүлэх алба хаагчид нь эргүүл постонд гарах, ой хээрийн түймэр унтраах, байгалийн гамшиг, ослоос хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ард иргэдэд ухуулга сурталчилгаа хийх зэрэг ажилд идэвх санаачлагатай оролцож байна. | 0.3 |
| Монгол улсын Засгийн газрын 2009 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан хяналтын тоонд багтаан 30 хүнийг дүйцүүлэх албанд авсан. Одоо аймгийн хэмжээнд 12 сум, 2 тосгонд 95 иргэн цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байна. Дүйцүүлэх алба хаагчид нь эргүүл постонд гарах, ой хээрийн түймэр унтраах, байгалийн гамшиг, ослоос хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ард иргэдэд ухуулга сурталчилгаа хийх зэрэг ажилд идэвх санаачлагатай оролцож байна.<br>Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаагчдын нэгдсэн сургалтыг 6-р сарын 3-наас эхлэн 14 хоног зохион байгуулж явуулсан. Энэ сургалтанд оролцсон бүрэлдэхүүнээр аймгийн удирдлагаас өгсөн үүргийн дагуу 10 хоног Өндөрхаан хотын тохижилт соёлжилтийн ажил хийлгэсэн. | 0.3 |
| Өндөрхаан хот, Баян-Овоо суманд илэрсэн цэргийн зориулалттай сум галт хэрэгслийг устгуулахаар Зэвсэгт хүчний Жанжин штабт хүсэлт тавьсаны дагуу 10 хүний бүрэлдэхүүнтэй Хайгуул устгалын бүлэг томилон ажиллуулж нийт 60 гаруй бөмбөг, их бууны сум, минийг тэсэлж устган аюулгүй болгосон. Аймгийн төвийн ойр орчимд илэрсэн 1939, 1945 оны дайны үед хэрэглэгдэж байсан байлдааны зориулалттай сум, галт хэрэгслийн үлдэгдлийг булж далдлан сэрэмжлүүлэг тавьж, энэ талаар орон нутгийн кабелийн телевиз, FM радиогоор ард иргэдэд сэрэмжлүүлж байна. | 0.3 |

| | |
|---|---|
| 2009 оны 6 сарын 9-11-ний өдрүүдэд ОХУ-ын Өвөр байгалийн муж улсад зохион байгуулагдсан Дорнод-Сибирийн үржлийн хонь, ямааны 6-р үзэсгэлэн худалдаанд аймгийн ЗДТГ-ын 2 хэлтсийн дарга, ХХААЖДҮ-ийн газрын дарга, мэргэжилтэн, Өмнөдэлгэр сумын Засаг дарга нар оролцож хөдөө аж ахуйн чиглэлээр туршлага судлав. 2009 оны 7 дугаар сарын 23-24-нд ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн зүүн үзэмчин хошууны төв Улиастай хотноо зохион байгууллагдсан “Номин ногоон тал” нэртэй баяр наадмын үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын зөвлөхөөр ахлуулсан төлөөлөгчид оролцлоо. 2009 оны 8 сарын 7-11-ний өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Хайлаар хотноо зохион байгуулагдсан 3 улсын үзэсгэлэн худалдаанд Хэрлэн сумын Засаг дарга, ХХААЖДҮ-ийн газрын дарга, АОЭХолбооны тэргүүн нар оролцов. Үзэсгэлэн худалдааны арга хэмжээнд Хэрлэн сумын "Цэцэн Хааны хүрээ" ХХК, 1-р сургуулийн багш Р.Алтанцэцэг, оёдолчин Э.Оюунцэцэг нарын бүтээл оролцож тусгай байрын шагнал хүртлээ. | 30 |
| 2009 оны 7 дугаар сарын 23-24-нд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошууны баяр наадмын үйл ажиллагаанд оролцсон төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд аймгийн Эрүүл мэндийн газрын нөхөн үржихүй, эрүүл ахуйн мэргэжилтэн, Мэргэжлийн хяналтын газрын эмчилгээ оншолгооны чанарын улсын байцаагч нар хамрагдаж Улиастай хотын уламжлалт анагаах ухааны эмнэлэг дээр туршлага судаллаа. Мөн Монгол улсын гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөрийн төсөлд уламжлалт анагаах ухааны чиглэлээр оюутан сургах, уламжлалт анагаах ухааны тоног төхөөрөмж авах талаар санал хүргүүлээд байна. | 30 |
| 2008 онд Манжуур хоттой байгуулсан хэлэлцээрийн дагуу Манжуур хотын Их сургуульд 5 оюутан суралцуулахаар аймгийн Засаг даргын 2009 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 9/782 тоот албан бичгээр санал хүргүүлсэн. Манжуур хотын удирдлагууд 9 дүгээр сард Өндөрхаан хотноо айлчилж хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулахаар төлөвлөсөн ч H1N1 вирусын томуу өвчний улмаас айлчлал тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна. | 10 |
| Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошууны удирдлагуудтай бөх, морин хуур, шатарын багш дасгалжуулагч өсвөрийн тамирчин сурагч солилцохоор санал солилцлоо. 2009 оны 8 дугаар сарын 7-11-ний хооронд Хайлаар хотноо болсон үзэсгэлэн худалдааны арга хэмжээнд оролцохдоо Хэрлэн сумын Засаг дарга Хайлаар тойрогийн намын даргатай дунд сургуулиудын хамтын ажиллагааны гэрээ байгуулах, сурагчид харилцан сургахаар санал солилцсон байна. | 10 |
| Аймгийн Хан Хэнтий чуулгын айлчлан тоглолт хийх тухай 9 дүгээр сарын 16-ны өдрийн 1/1020 тоот албан бичгийг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Шинэ барга зүүн хошууны захиргаанд хүргүүлсэн хэдийч H1N1 вирусын томуу өвчний улмаас олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг тус хошуунд хориглосон тул харилцан тохиролцсоны дагуу 2010 онд зохион байгууллахаар түр хойшлуулаад байна. | 10 |

| | |
|---|---|
| 2009 оны 7 дугаар сарын 23-24-нд ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн зүүн үзэмчин хошууны төв Улиастай хотноо зохион байгууллагдсан “Номин ногоон тал” нэртэй баяр наадмын үйл ажиллагаанд аймгийн төлөөлөгчид оролцож сур харвааны төрөлд аймгийн харваач Г.Баяржаргал 86 харваачдаас 6 дугаар байрт, шатрын төрөлд өрсөлдсөн шатарчин З.Бямбадорж шилдэг 8-д шалгарсан амжилтыг үзүүллээ. | 30 |
| | 35.1 |

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ХАНГАХ ЗОРИЛТ

үлэх замаар эдийн засгийн бүтцийг сайжруулж, өсөлтийг хангана.

| | |
|---|---|
| 2009 онд Өндөрхаан хотод холбогдох мэргэжилтэнгүүд ирж дулаан хангамжийн өнөөгийн байдалд газар дээр нь судалгаа, шинжилгээ хийж техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж байна. | 10 |
| | 2010 онд |
| | 2011 онд |
| | 2010 онд |
| | 2011 онд |
| | 2011-2012 онд |
| Өндөрхаан-Сүмбэрийн чиглэлийн эхний 50 км зам ашиглалтанд ороод байгаа бөгөөд дараачийн 50 км замыг үргэлжлүүлэн барьж байна. 2009 оны байдлаар замын далангийн дүүргэлтийн ажил дууссан. 2010 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтанд 7.0 тэрбум төгрөг тавигдаад байна. | 30 |
| Өндөрхаан хотын 1,4 км урттай хатуу хучилттай асфальтбетон автозамын ажлыг зам засвар арчлалтын "Харгуй" ТӨҮГ 329.0 сая төгрөгт багтаан барьж дуусган 2009 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр Улсын комиссын шийдвэрээр байнгын ашиглалтанд оруулаа. | 30 |
| 2009 онд Өндөрхаан хотын төв замуудад 3 км тэмдэглэгээ, 4 гарцын тэмдэглэгээг хийсэн байна. Өндөрхаан хотын шинээр баригдсан 1,4 км замд 2 тэмдэг, замын голын тэмдэглэгээ болон 2 гарцыг уг замыг барьсан Харгуй ХХК өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн. Уг замд үргэлжлүүлэн замын гарц, тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлэх ажлыг Хэрлэн сумын ЗДТГазрын Хот тохижилтийн хэсэг гүйцэтгэх боловч хөрөнгийн асуудлаас болж удаашралтай байна. | 10 |

| | |
|---|---|
